



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,  
<http://www.mmhi.gov.mn>

2018. 02. 28 № 01/557

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД  
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА**

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжсэн гадаадын зээл, тусламжийн төслүүдийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг хавсралтуудын хамт хүргүүлж байна.

Гадаад хамтын ажиллагааны 7 төслийн хэрэгжилт 61.4 хувьтай байна.

Хавсралт 40 хуудастай.

  
Ч.ХҮРЭЛБААТАР

08 024

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД  
ХЭРЭГЖСЭН ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТЭНД  
ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА  
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

2018 оны 02 дугаар сарын 27-ны өдөр

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2017 онд хэрэгжсэн гадаадын зээл, тусламжийн төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилго, зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

Гадаад хамтын ажиллагааны төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам, Сангийн яамны 2018.01.25-ны өдрийн 10/584 албан бичгийг тус тус удирдлага болгов.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)-ны Геологийн бодлогын газар, Хүнд үйлдвэрийн бодлогын газар, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Ашигт малтмал, газрын тосны газраас тайлагнасан 7 төслийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж (Хавсралт 5), төслүүдийн үнэлгээ, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт, төлөвлөсөн ажлын биелэлт, төслийн хүрээнд бий болсон ажлын байр, сургалтын судалгааны тайлан, мэдээг нэгтгэсэн. (Хавсралт 1-4)

Хөтөлбөр, төслийн зорилтыг хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах үр дүнг үнэлгээ хийх үед хүрсэн бодит үр дүнгийн түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 7 гадаадын зээл, тусламжийн хөтөлбөр, төсөл хэрэгжсэн бөгөөд эдгээр төслүүдээс 1 төсөл нь буцалтгүй тусламж, зээлээр, 1 нь өөрсдийн санхүүгийн боломжоор, бусад нь буцалтгүй тусламжаар хэрэгжиж байна.

Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн төслийн хэрэгжилт 2017 оны жилийн эцсийн байдлаар 61.4 хувьтай, үүнээс удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан 1 /90-100 хувь/, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 3 /70 хувь/, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай 3 /40 хувь/ хөтөлбөр, төсөл байна гэж үнэлсэн (Хүснэгт 1).

Гадаадын зээл, тусламжийн төслийн хэрэгжилтийн үнэлгээний нэгтгэл  
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

Хүснэгт 1

д/д	Төслийн нэр	Зорилтын тоо	Үнэлгээ (хувь)					Хэрэгжилт (хувь)
			100	70	40	0	/-/	
1	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (MINIS)	4		1				70
2	Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) 4-р үе шат	1	1					100
3	Монгол Улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх (СЕСМИМ) төсөл	1			1			40
4	Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT). Хүний нөөцийн ур чадварт суурилсан тогтолцоо-MERIT	1			1			40
5	Австрали- Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /АМЕР/, Веб-д суурилсан Геологийн мэдээллийн метадата-каталоги систем /Монгеокат/-ийг хөгжүүлэх, АМЕП	1		1				70
6	АМГТГ-ын Уул уурхай, газрын тосны төв лабораторийн үйл ажиллагааг дэмжих- К-Петро	1			1			40
7	Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх төсөл-КИГАМ	1		1				70
Нийт дүн		10	1	3	3	0	0	

Тайлант хугацаанд Монгол орны зүүн болон урд хэсгээр 1:50 000-ны маштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх чиглэлээр хэрэгжүүлж байгаа БНСУ-ын КИГАМ төслийн хэрэгжилтэнд илүү ахиц гарсан байна. Энэхүү хөтөлбөр, төслийн хүрээнд Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:50000-ны масштабын геологийн зураглал ерөнхий эрлийн ажлыг хийх заавар, тавигдах шаардлагын дагуу амжилттай хийгдсэн.

Сангийн яамны 2018.01.25-ны өдрийн 10/384 дугаартай албан бичгийн хавсралт 4-х хүснэгтийн дагуу гадаад зээл, тусламжийн төслүүдийн үнэлгээ, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт, төлөвлөсөн ажлын биелэлт, төслийн хүрээнд бий болсон ажлын байр, сургалтын судалгааны талаарх мэдээллийг төсөл хэрэгжүүлэгчид бүрэн тайлагнасангүй.

Хөгжлийн тусламжийн тухай Канад Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд 2016.09.08-ны өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн 7 дугаар зүйл. "Тайлагнах зохицуулалт"-д "Канад Улсын засгийн газар Монгол Улс дахь элчин сайдын яамаараа дамжуулан жилийн тайлан, хараат бус хяналтын тайланг Монгол Улсын Засгийн газарт Сангийн яамаар дамжуулан хүргүүлэх бөгөөд гадаадын тусламжийг хүлээн авах, зарцуулах, удирдах, бүртгэх тайлагнах тухай Монгол Улсын дүрэм, журамтай нийцүүлнэ" хэмээн заасныг үндэслэн Мерит, Сесмим төслүүд нь санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт, төлөвлөсөн ажлын биелэлт, төслийн хүрээнд бий болсон ажлын байр, сургалтын судалгаа зэргийг салбарын яам, агентлагт ирүүлээгүй болно. (Хавсралт 6)

Дөрөв. Дүгнэлт

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжсэн гадаадын зээл, тусламжийн 7 төслийн хэрэгжилт 2017 оны жилийн эцсийн байдлаар 61.4 хувьтай үнэлэгдэв.
2. Засгийн газар хоорондын хэлэлцээр, харилцан ойлголцлын санамж бичиг зэрэгт Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын асуудлыг ерөнхий тусгасан, жилийн тайлан, хараат бус хяналтын тайланг Сангийн ямаар уламжлан, Засгийн газарт тайлагнана гэсэн шалтгаанаар зарим төсөл хэрэгжүүлэгчид тайлан, мэдээг салбарын яам, агентлагт ирүүлэхгүй байгаагаас тус яам нь хэрэгжилт, үр дүнг холбогдох мэдээллийн хамт нэгтгэн, нэгдсэн дүн шинжилгээ хийх боломж бүрдсэнгүй.
3. Гадаадын зээл, тусламжийн төслүүдийн санамж бичиг, хэлэлцээр, гэрээ зэрэг эрх зүйн зүйн баримт бичгүүд яам, агентлагийн албан хэрэгцээнд байхгүйн улмаас ХШҮ бүрэн төгс хийх боломжгүй байна.
4. Дээрхи нөхцөл байдлаас гадаадын зээл, тусламжийн төслийн үр дүнг салбарын бодлого, төлөвлөлт болон улс орны хөгжлийн бодлого, төлөвлөлттэй бүрэн уялдуулж чадахгүй байна гэж үзэж байна.

Тав. Санал, зөвлөмж

1. Засгийн газар хоорондын хэлэлцээр, харилцан ойлголцлын санамж бичиг зэрэгт геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хүрээнд хэрэгжсэн гадаадын зээл, тусламжийн төслийн тайлан, мэдээг салбарын яам, агентлагт Монгол Улсын хууль тогтоомжинд заасан хугацаанд үнэн зөв тайлагнах, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулахад чиглэгдсэн заалтуудыг зайлшгүй тусгах шаардлагатай байна.
2. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын асуудал хариуцсан яам, агентлагийн нэгжүүд нь төслүүдийн хэрэгжилтийн хүрсэн үр дүн, ажлын чанар, үр өгөөжид мэргэжлийн өндөр түвшинд анхаарч, салбарын бодлого, төлөвлөлттэй уялдуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу тайлан, мэдээг хугацаанд нь үнэн бодит тайлагнаж хэвших шаардлагатай байна.
3. Салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа төслүүдийн Монгол хэл болон НҮБ-ын албан ёсны хэлээр байгуулагдсан санамж бичиг, хэлэлцээр, гэрээ зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг асуудал хариуцсан нэгжүүд албан хэрэгцээнд ашиглах, Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай байна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хянасан:

ХШҮДАГ-ын дарга

Ц.Одхүү

Танилцуулга боловсруулсан:

ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн

Н.Баатар /2018.02.27/

Төслийн хэрэгжилтэнд ХШҮ хийсэн:

ХШҮДАГ-ын мэргэжилтэн

Д.Батнайрамдал

**ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

(2017 оны жилийн эцсийн байдлаар )

1	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1.	<b>Төслийн Нэр: “Хүний Нөөцийн Ур чадварт Суурилсан Тогтолцоо”</b>	MERIT төслийн зорилго нь төрийн байгууллагуудын менежментийг сайжруулах арга замаар олборлох салбарын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх явдал юм.			
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Буцалтгүй тусламж			
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Канад Улсын Засгийн газрын MERIT төсөл болон Ашигт малтмал, газрын тосны газар Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:			
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Төрийн байгууллагуудын менежментийг сайжруулах арга замаар олборлох салбарын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмэр оруулахад мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, суралцах бололцоогоор хангах			
5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	Буцалтгүй тусламж		
		Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь
		Багц 1			
		Багц 2 (г.м)			
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	<i>Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.</i>			
	1-р зорилтын хүрээнд:  Хүрэх үр дүн 1:	<p>Төрийн байгууллагын хүний нөөцийн ур чадварт тулгуурлан хүний нөөцийн бодлогыг тодорхойлоход чиглэсэн үйл ажиллагаанууд зохион байгуулж байна.</p> <p>MERIT төсөл болон Ашигт малтмал, газрын тосны газар хооронд Чадавхи Хөгжүүлэх Төлөвлөгөөнд (ЧХТ) 2016 оны 5 сард гарын үсэг зурсан бөгөөд түүнээс хойш өнөөг хүртэл буюу 2017 оны 12 дугаар сарыг дуустал хугцаанд Ашигт малтмал, газрын тосны газарт нийт 12 Канад зөвлөх 1 сарын хугацаатай ирж ажилласан.</p> <p>Канад зөвлөхүүдийн Газрын тосны бодлого боловсруулах, Хүний нөөцийн ур чадвар хөгжүүлэх тогтолцоо, Жендерийн тэгш байдал, Газрын тосны нөөцийн ангиллын систем ба эрх зүйн орчин, Хяналт шинжилгээ, үнэлгээ, Уул уурхайн нөлөөллийн статистик гаргах чиглэлүүдээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлсэн байна.</p> <p>Төслийн дэмжлэгтэй дараах сургалтууд болон техник арга зүйн туслалцаануудийг үзүүлсэн:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Канад улсад 2016 оны 7 дугаар сарын 17-ны өдрөөс 8 дугаар сарын 1-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Канадын газрын тосны салбарын эрх зүйн орчин, салбарын үйл ажиллагааны зохицуулалт, өнөөгийн байдал сэдэвт сургалтад Ашигт малтмал, газрын тосны газрын ахлах мэргэжилтэн А. Түвшинжаргал суусан.</li> <li>• Газрын тосны нөөцийн ангиллын систем ба эрх зүйн орчин сургалтыг Канад улсын газрын тосны зөвлөх SPROULE компанийн тусламжтайгаар 2017 оны 1 дүгээр сарын 9-12-ны хооронд Ашигт малтмал, газрын тосны газарт зохион байгуулсан. Тус сургалтад нийт 17 албан хаагч суусан.</li> <li>• Газрын тосны нөөцийн ангиллын сургалтад Ашигт малтмал, газрын тосны газрын 2 мэргэжилтэн 2017 оны 9 дүгээр сард Канад улсад зохион байгуулагдсан сургалтад суусан.</li> <li>• MERIT төслийн зүгээс Ашигт малтмал, газрын тосны газрын сургалтын танхимыг тоног төхөөрөмжөөр хангах зорилгоор Канадын СЕСМИМ төсөлтэй хамтран сургалтын тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээнд 2017</li> </ul>			

		<p>оны 11 дүгээр сарын 2-ны өдөр гарын үсэг зурж, тоног төхөөрөмжийг нийлүүлэн сургалтын танхимыг тохижуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Багийн ажиллагаа, цагийн менежментийн сургалтыг 2017 оны 5 дугаар сард Ашигт малтмал, газрын тосны газрын мэргэжилтнүүд болон ахлах мэргэжилтнүүдийн хүрээнд зохион байгуулсан.</li> </ul>				
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Төсөл нь 2017 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход хүндрэлтэй, ойлгомжгүй зүйлүүд гарч байсан. Төслийг хэрэгжүүлэхэд АМГТГ-ын холбогдох хэлтсүүдийн мэргэжилтнүүд Канад улсаас ирсэн зөвлөхтэй хамтран ажиллах шаардлага тулгарсан бөгөөд энэ нь тухайн мэргэжилтнүүдийн хувьд өөрсдийн үндсэн ажлаа хийхэд цаг хугацааны хувьд хүндрэл болж байсан. Олборлох салбар хөгжсөн Канад улсаас чиглэл бүрээр туршлагатай мэргэжилтнүүд ирж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн нь Ашигт малтмал, газрын тосны газрын бүх түвшний ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэлийн үнэлгээ зэргийг илүү тодорхой болгоход дөхөм болсон.</p>				
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>Канад Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй энэхүү төсөл нь одоогоор Монгол Улсын Уул уурхай, үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар болон Байгаль орчин аялал жуулчлалын яам зэрэг төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа бөгөөд Ашигт малтмал, газрын тосны газар нь 2018 онд энэхүү төслийн загвар байгууллагаар ажиллах болно.</p>				
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		70%		70%	... %	... %
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (УУХҮЯ)	Нэгдсэн үнэлгээ				
		40%				
11.	(ЗГХЭГ-ын үнэлгээ)					

## ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ \*

(2017 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл								
1	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	Төсөл, хөтөлбөрийн зорилго: Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төслийн хөгжлийн зорилт нь санхүүжилтийн эх үүсвэрээс үл хамааран уул уурхайн болон боловсруулах үйлдвэрийг дэмжихийн тулд дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт хийхийг дэмжих, дэд бүтцийн төслүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх дотоод чадавхийг нэмэгдүүлэхэд оршино.								
2	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын төсөв (зээл) буцалтгүй тусламж: Хөнгөлөлттэй зээл + Буцалтгүй тусламж								
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн Яам Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: БОАЖЯ, УУХҮЯ, ЭХЯ, ҮХГ								
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Дор хаяж хоёр техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж бэлэн болгосон байх Зорилт 2. Төр, хувийн хэвшлийн санхүүжилтэд төслийн танилцуулгыг бэлдэх сайн туршлага, дүрэм журмыг боловсруулах								
5	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)								
		Үүнд:	Төсөв (2017 он)			Гүйцэтгэл			Хувь	
		Бараа	55,550,387.79			57,700,868.04			103.87	
		Зөвлөх үйлчилгээ	7,047,392,439.69			5,783,238,395.92			82.06	
		Сургалт	454,412,181.17			408,780,952.90			89.96	
	Үйл ажиллагаа	506,459,391.35			521,576,371.74			102.98		
6	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.								
	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:	1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл: Төслийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих томоохон зургаан дэд төслөөс гурван техник эдийн засгийн үндэслэл боловсруулагдаж дууссан бөгөөд эдгээр төслүүдэд тавигдаж буй байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний ажлууд дуусах шатандаа явж байна.								
	2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Санамж: Хүрэх гол үр дүнг бичнэ.	2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл: Төслүүдэд тавигдах шалгуур үзүүлэлт болон аргачлал дээр зөвшилцөх, яамдуудын чадавхи бэхжүүлэх сургалтууд болон хэрэгжиж байгаа төслүүдээр дамжуулан биелсэн.								
7	3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:	3-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан: Усны сав газруудыг байгуулах, бэхжүүлэх, усны суурь судалгаа, нөөцийн үнэлгээ, газрын доорх усны мониторингийн сүлжээ байгуулах зэрэг ажлууд бүрэн хийгдэж дууссан. Сав газрын нэгдсэн менежментийн төлөвлөгөө, мониторингийн сүлжээг өргөтгөх, мэдээллийн баазыг сайжруулах, усны чанарын судалгааны ажлууд хэрэгжиж байна.								
	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Төслийн худалдан авах ажиллагаа сонирхогч болон оролцогч талуудын зөвшилцөл, ойлголцлоос ихээхэн хамаарах тул удаан хугацаагаар саатах, мөн үнэлгээний хороо болон ажлын хэсэгт олон яамдуудын төлөөлөл байдаг тул удаашрах, хүлээлт үүсэх нөхцөл байдлыг тооцож, төлөвлөгөө гаргах, хэрэгжилтэд анхаарах								
8	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Захиалагч талууд, хэрэгжүүлэгч талууд, санхүүжүүлэгч тал, гүйцэтгэгч талууд хэрхэн хамтарч ажилласан талаар энд бичнэ.								
9	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж ... %	Зорилтын тоо		Зорилт 1		Зорилт 2		Зорилт 3	
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (УУХҮЯ)	Нэгдсэн үнэлгээ 70%								
11	(ЗГХЭГ-ын үнэлгээ)									

\* "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын Хавсралт 5

**ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

(2017 оны жилийн эцсийн байдлаар )

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл						
1.	Төслийн Нэр: Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх төсөл	КИГАМ төслийн зорилго нь “Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх” төслийн талбайн хэмжээнд геологийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэх						
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	БНСУ-ын Геологийн Шинжлэх Ухаан, Байгалийн Нөөцийн Хүрээлэн						
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: КИГАМ төсөл болон Ашигт малтмал, газрын тосны газар Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, хайгуулын хэлтэс						
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. “Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх” төслийн талбайн хэмжээнд геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх						
5.	Зардал	Төсөв (нийт шаардагд ах зардал)	72 000 ам.доллар					
		Үүнд:	Төсөв (он)		Гүйцэтгэл		Хувь	
	Багц 1	72 000 ам.доллар	2017	72 000 ам доллар	2017	100 %		
	Багц 2 (г.м)							
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	<i>Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.</i>						
	1-р зорилтын хүрээнд:  Хүрэх үр дүн 1:	<p><b>Бүрэлдэхүүн:</b> Хээрийн ажилд төслийн ахлагч Д.Эрдэмбилэг, ахлах геологич Б.Сүхбаатар, геологич Б.Ренчиндорж, А.Рэнцэнбадам, техник геологич Ш.Баярмагнай, угаагч С.Чулуунпүрэв, зайлагч Э.Октябрь, шлих авагч Г.Энхтулга, тогооч О.Сүнжидмаа, жолооч Х.Пүрэвдорж, н.Оросоо болон 4237 УНМ улсын дугаар бүхий Т.ЛандКруйзер-76, Уаз фургон маркийн 4661 ХӨА дугаартай 2 тээврийн хэрэгсэлтэй , нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.</p> <p><b>Гүйцэтгэсэн ажлууд:</b> 2017 оны хээрийн ажлаар Цогтцэций-50 төслийн баг К-48-22-Б, К-48-22-Г хавтгайд 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг хийх заавар тавих шаардлагын дагуу хийж гүйцэтгээд байна. Хээрийн ажлаар нийт 2 хавтгайн хэмжээнд буюу 747.55 км2 талбайд 1:50 000-ны масштабтай зураглалын ажил хийсэн. Зураглалын маршрутыг чулуулгийн судалд хөндлөн чиглэлтэй төлөвлөж, түүний дагуу гүйцэтгэхдээ геологийн тогтоцын зэрэглэл хүнд, нийлмэл тогтоцтой хэсэгт маршрут хоорондын зайг 500м-ээс хэтрүүлэхгүй, ажиглалтын цэг хоорондын бичиглэлийг тасралтгүй бичиж, хурдас чулуулгийн хил заагийг нарийвчлан тогтоож маршрутын ажил хийсэн. Харин нэгэн төрлийн хүндас төрхөөрөө хийж байсан.</p>						



хурдас, гарш илэрцгүй хэсэгт маршрутын уртыг 10-15км, хоорондын зайг 700-800м, цэг хооронд 700-1000м байхаар төлөвлөж түүний дагуу хийж гүйцэтгэсэн.

Маршрутын явцад ашигт малтмалын хувьд сонирхолтой хувирал, эрдэсжилт бүхий хэсгээс хэмжээ, хувирлын зэргээс нь хамаарч штуф болон анхдагч геохимийн сорьцлолт хийсэн. Мөн стратиграфийн хувьд сонирхолтой, чулуулгийн зүссэн болон хучсан хил зааг бүхий хэсгийг фото зураг, схем зургуудаар баяжуулан баримтжуулсан. Мөн маршрутын явцад нэршлийн хувьд эргэлзээтэй болон формац, бүрдэл, субвулкан биет, дэл судлын чулуулгуудыг төлөөлөх дээжүүдээс шлифийн дээж авсан.

Маршрут хийсний дараа ИТА-чид маршрутаа нэгтгэн нэгдсэн геологийн зурагт буулган, хавсралт байдлаар баримт материалын зураг, сорьц бүртгэлийн журналаа хөтөлж, анхдагч баримт бүрдлүүдээ цуглуулан баримтжуулсан.

Бүх маршрутаа хүлээн авч нэгдсэн геологийн зураг зохиосны дараа зарим хил зааг нь тодорхойгүй чулуулгийн хил заагийг нийлүүлж, интрузив, субвулкан, дэл судлын төлөөлөх чулуулгаас силикат дагалдах байдлаар шлих, анхдагч геохимийн сорьцуудыг шалган холбох маршрутын явцад авсан.

Өмнөх судлаачдын тогтоосон эрдэсжсэн цэг, илрэлүүдийг маршрутаар дайран эрэл-зураглалын хосолсон маршрут хийсэн. Харин маршрутын явцад илрүүлсэн төмрийн илрэл дээр хил зааг гарш илэрц олох зорилгоор эрлийн маршрут, сорьцлолтын ажил гүйцэтгэн дөрөвдөгчийн сэвсгэр хурдас хэмээн зурагласан хөндий дэх жалганд эргийн цэвэрлэгээ хийж, шурф малтсан.

### **Зураглалын маршрутын үр дүн:**

- Өмнөх судлаачид К-48-22-Б-б хавтгайн 1253,0 тоот толгойн , К-48-22-Г хавтгайн 1171,0 тоот орчимд Сайншанд (C<sub>1</sub>sh) формацын хурдас ялгаж фауны үлдэгдэл олсон тухай тэмдэглэлийн дагуу бид маршрутын явцад шалгаж ургамлын үлдэгдэл олж баталгаажуулсан бөгөөд шинжилгээнд өгөхөөр бэлтгэсэн.
- Мөн маршрутын явцад К-48-22-Г хавтгайн урд зүүн урд хэсгээр тархсан цэрдийн хурдаст маршрут хийж чулуужсан модны үлдэгдэл бүхий хэд хэдэн цэг илрүүлж төлөөлөх дээж сорьц авч шинжилгээнд өгөхөөр бэлтгэлээ.
- К-48-22-Б-б хавтгайд байрлах Баруун Богд уул орчим чулуулгийг өмнөх судлаачид пермийн шүлтлэг боржин гэж ангилсан нь маршрутын явцад ажиглалтаар эргэлзээтэй байсан бөгөөд бид жижиг ширхэгтэй боржин сиенит буюу нас нь залуу байх магадлалтай гэж үзэж үнэмлэхүй нас тодорхойлох шаардлагатай байна. К-48-22-Б-а,б хавтгайд байрлах пермийн субвулкан биетийн хувьд бусад чулуулагтай харьцах хил зааг, фацыг нь нэг бүрчлэн ангилан нарийвчлан зураглаж өглөө.
- К-48-22-Б Хавтгайд тархсан риолит, трахириолитын биетүүд нь баруун хойш, зүүн хойш чиглэсэн хагарлуудын нөлөөгөөр хувирсан байгаа нь цөөнгүй ажиглагдаж байлаа. Жишээ нь: Хавтгай хүрэн уул (1324) хойд, БХ энгэрт БХ чиглэлтэй хагарлын 2 талаар ан цаваар хүчтэй исэлдсэн бүс тогтоогдлоо.
- К-48-22-Г хавтгайд өмнөх судалгаагаар тогтоогдоогүй цэрдийн сайн мөлгөржсөн хайрга бүхий хурдас хуримтлал 1212.9 тоот орчимд тархаж буйг зураглалын үед олж зурагт буулгав.
- К-48-22-Б талбайд АЦ-9037/2-д тунамал вулканоген чулуулагтай холбоотой төмрийн тунамал эрдэсжилт болох /магнетит

		<p>илменит/-ын 0,1-2см-н зузаан хүдэржилт илэрсэн хэсэгт 3м урт 0,6м гүн суваг малтсан бөгөөд үүний үргэлжлэл байж болох магнетитийн хэмхдэс бүхий илэрц уг цэгээс зүүн хойш 2,5 км зайд 1299 тоот өндөрлөгийн урд хэсэгт олж тогтоосон. Үүний гарш илэрцийг олох зорилгоор эрлийн маршрут хийсэн боловч пермийн сувулкан болон дэл судлын чулуулгаар зүсэгдэж багахан хэмжээний үлдэгдэл үлдсэн байна гэж дүгнэсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Баруун Богд уулын урд зураглалын зориулалттай шурф малтаж эргийн цэвэрлэгээ хийсэн. Үүний үр дүнд өмнөх судлаачдын дөрөвдөгчийн настай гэж тэмдэглэсэн хурдаст зүсэлт хийж улаан, цагаан шаврын үе бүхий неогений хурдас хуримтлагдсан болохыг баримтжуулж, бичиглэлийг хийсэн.</li> <li>• 2017 оны 9 дүгээр сард БНСУ-ын КИГАМ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран Зогдор уулын талбайд 300X300м-ын тороор хоёрдогч геохими сорьц авч К-48-22-Б-а хавтгайд холбон шалгах маршрут хамтран хийсэн. Тэдгээрийн авсан нийт 236ш хоёрдогч геохимийн дээжийг шигшиж 200гр жинтэй болгон лабораторид хүргүүлэхээр бэлдсэн.</li> <li>• 2017 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Зогдор уулын талбайд Drone Inspire багажаар 40 га талбайд 120м-ийн өндөрт 12 шугамын нислэг үйлдэж агаарын зураг авсан.</li> <li>• 2017 оны хээрийн ажлын явцад 1ш ховилон, 60ш анхдагч геохими, 25ш цэглэн, 30ш шлиф, 15ш силикат сорьцлолт хийлээ. Мөн талбайн хэмжээнд 420 шлих болон 756 урсгал геохимийн дээжлэлт хийн лабораторийн шинжилгээнд илгээсэн.</li> </ul>										
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Төслийн 2017 оны хээрийн ажлыг монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:50000-ны масштабын геологийн зураглал ерөнхий эрлийн ажлыг хийх заавар тавих шаардлагын дагуу амжилттай хийсэн. Энэ нь өмнөх жилүүдийг бодвол кондицийн гэдэг утгаараа ололттой болсон. Төслийн хээрийн ажлыг хэрэгжүүлэхэд БНСУ-ын КИГАМ-тай гэрээ байгуулсан хугацаа болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан хээрийн ажил оройтож эхэлсэн нь гэрээт хугацаанд төлөвлөгөөт ажлыг гүйцэтгэхэд цаг хугацааны хувьд шахуу байсан. Дараа жилийн хээрийн ажил болон суурин боловсруулалтын ажлын хугацааг харгалзан тооцож эрт гэрээг байгуулах шаардлагатай. Мөн төсөл дээр ажиллаж буй мэргэжилтнүүд солонгос мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахын тулд хэлний болон мэргэжлийн сургалтанд суулгах шаардлагатай байна.										
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Ашигт малтмал, газрын тосны газар болон БНСУ-ын Геологийн шинжлэх ухаан, эрдэс баялгийн хүрээлэн /КИГАМ/-ээс хэрэгжүүлж буй энэхүү төслийг Ашигт малтмал, газрын тосны газар 2017 онд маш амжилттайгаар зохион байгуулж тухайн оны тайланг КИГАМ-д хүлээлгэн өгсөн.										
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="422 1501 535 1575">Биелэлт дундаж</th> <th data-bbox="535 1501 787 1575">Зорилтын тоо</th> <th data-bbox="787 1501 1031 1575">Зорилт 1</th> <th data-bbox="1031 1501 1234 1575">Зорилт 2</th> <th data-bbox="1234 1501 1567 1575">Зорилт 3</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="422 1575 535 1774">90%</td> <td data-bbox="535 1575 787 1774"></td> <td data-bbox="787 1575 1031 1774">90%</td> <td data-bbox="1031 1575 1234 1774">.. %</td> <td data-bbox="1234 1575 1567 1774">... %</td> </tr> </tbody> </table>	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	90%		90%	.. %	... %
Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3								
90%		90%	.. %	... %								
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ УУХҮЯ	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="535 1774 1567 1827">Нэгдсэн үнэлгээ</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="535 1827 1567 1911">70 %</td> </tr> </tbody> </table>	Нэгдсэн үнэлгээ	70 %								
Нэгдсэн үнэлгээ												
70 %												
11	(ЗГХЭГ-ын үнэлгээ)											

**ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

(2017 оны жилийн эцсийн байдлаар )

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл		
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	<p>Монгол Улсын Засгийн газар болон Австрали Улсын Засгийн газрын хооронд “Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийн тухай дэд гэрээг 2015 онд байгуулсан. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарын хөгжлийг дэмжих, Монгол Улсын иргэд эрдэс баялгийн салбарын үр шимийг хүртээмжтэй, тогтвортой байдлаар хүртэх боломжийг бий болгоход хувь нэмэр оруулахад чиглэнэ.</p> <p>Төсөл, хөтөлбөрийн зорилго:</p> <p>Тус хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарын бодлого, зохицуулалт, засаглалыг дэмжих, хамтран ажиллагч талуудын түншлэлийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллахад оршино.</p>		
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	<p>Улсын төсөв (зээл) буцалтгүй тусламж:</p> <p>Австрали Улсын Засгийн газрын буцалтгүй тусламж</p>		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага:</p> <p>“Адам Смит Интернэйшнл Монгол” ХХК</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:</p> <p>УУХҮЯ-ны Геологийн бодлогын газар</p> <p>АМГТГ-ын Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв</p>		
	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1. Монгол Улсын эрдэс баялгийн салбарын бодлого, зохицуулалт, засаглалыг дэмжих,</p> <p>Зорилт 2. УУХҮЯ, АМГТГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан геологийн мэдээ, мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэн, хэрэглэгчдэд түргэн шуурхай бодитоор хүргэхэд дэмжлэг үзүүлэх,</p> <p>Зорилт 3. Геологийн төв лабораторийн (ГТЛ) техникийн болон институцын чадавхид үнэлгээ хийх.</p>		
5.	Зардал	Төсөв (нийт шаардагд ах зардал)	1 сая австрали доллар	
		Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл
		Багц 1	2017	Хувь
6.	<p>Төсөл, хөтөлбөрийн зорилт:</p> <p>1-р зорилтын хүрээнд:</p> <p>Хүрэх үр дүн 1:</p>	<p>Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.</p> <p>1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл</p> <p><b>1. Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулсан.</b></p> <p>Монгол Улсад Үндэсний геологийн алба байгуулахтай холбогдуулан Газрын хэвлийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажлыг хийсэн. УУХҮЯ, АМГТГ, Монголын Геологийн</p>		

Холбоотой уулзаж ажлын төлөвлөгөө, энэхүү хуулийн шинэчлэлтэй холбоотой зохицуулалтын хүрээ, үзэл баримтлал, Газрын хэвлийн тухай хуультай холбоотой өмнө хийгдэж байсан ажлын талаар санал солилцож, тухайн хамтрагч талын байр суурийг тодруулсан.

Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эхний хувилбар, холбогдох хууль тогтоомжид оруулах нэмэлт өөрчлөлт, хуулийн төслийн Үзэл баримтлал, Хуулийн төслийн танилцуулгын төслийг эцэслэн боловсруулж УУХҮЯ-нд хүргүүлсэн.

**2. Үндэсний геомэдээллийн сан хөтөлбөр боловсруулахад хамтран ажиллаж байна.**

Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны (УУХҮЯ) Геологийн бодлогын газрын “Үндэсний геомэдээллийн сан” хөтөлбөр боловсруулах Ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хамтрагч талуудын төлөөлөлтэй уулзаж, геомэдээлэл хүлээн авах, боловсруулах, түгээх талаарх өнөөгийн байдал, тулгамдсан асуудлын талаар зөвлөлдсөн. Мөн геомэдээлэл сангийн үйл ажиллагааны талаар олон улсын туршлага (Австрали, ОХУ, Казакстан, Хятад, Канад), судалж, Геологийн бодлогын газраас зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэгт танилцуулсан.

**3. Үндэсний геомэдээллийн нэгдсэн сангийн (ҮГМС) загвар, төсөөллийн тайланг боловсруулсан.**

Энэхүү тайланг АМГТГ-ын Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн (ЭБМТТ) удирдлаган дор боловсруулсан бөгөөд нийт 10 орны геомэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар, геомэдээллийг цуглуулах, хадгалах, шинэчлэх, түгээхтэй холбогдсон харьцуулсан судалгааг хийсэн.

**4. Австрали улсын уул уурхайн салбарын туршлага судлах ажлын айлчлал зохион байгуулсан.**

Австрали Улс дахь ажлын айлчлалыг 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 11 дүгээр сарын 3-ны өдрүүдэд төлөөлөгчдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан. Үүнд УИХ-ын гишүүн-4, УУХҮЯ-ны дэд сайд болон 3 албан хаагч, АМГТГ-2 албан хаагч, Сангийн яам-1.

- Төлөөлөгчид 10 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд Канберра хотод ажиллаж, Австрали Улсын Гадаад хэргийн сайд Жули Бишоптой уулзсан. Мөн Австрали Улсын Геологийн алба, Гадаад харилцаа худалдааны яам, Сангийн яам зэрэг бусад төрийн байгууллагын төлөөлөлтэйтэй уулзах цуврал уулзалтуудыг зохион байгуулсан.
- Төлөөлөгчид 10 дугаар сарын 30-ны өдрөөс 11 дүгээр сарын 2-ны өдрүүдэд Мелбурн хотод ажиллаж, Олон улсын уул уурхай, эрдэс баялгийн чуулга уулзалтад (IMARC) оролцсон. Энэхүү чуулга уулзалтын үеэр УУХҮЯ, АМГТГ-аас хөрөнгө оруулагчдад зориулан (60 гаруй оролцогч) “Монгол улс-IMARC”-т бизнес форум (Mongolia@IMARC) зохион байгуулсан.
- Олон улсын уул уурхай, эрдэс баялгийн чуулга уулзалтын (IMARC) үеэр УУХҮЯ болон АМГТГ Монгол Улсын үзэсгэлэнгийн талбайг ажиллуулж, “Монгеокат” систем, хөрөнгө оруулагчдад зориулсан гарын авлага, хувийн хэвшлийн байгууллагуудын төсөл, хөтөлбөрүүдийг сонирхогч талуудад танилцуулсан.

	<p>2-р зорилтын хүрээнд:</p> <p>Хүрэх үр дүн 1:</p> <p>Санамж: Хүрэх гол үр дүнг бичнэ.</p>	<p>2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл</p> <p><b>Монгол Улсын геологийн мэдээллийн каталоги систем (Монгеокат) хөгжүүлсэн.</b></p> <p>Геологийн мэдээлэл нээлттэй, хүртээмжтэй байх нь хайгуулын явцад гарах эрсдлийг бууруулж, хөрөнгө оруулалт татах нэг гол нөхцөл болдог. Монгеокат нь Геологийн баримтын төв архивт хадгалагдаж байгаа геологийн мэдээллийн хураангуйг хэрэглэгчдэд хүргэх зорилготой, 2 бүрэлдэхүүн хэсэгтэй нэгдсэн систем. Нэг бүрэлдэхүүн хэсэг нь цахим сүлжээний орчинд орон зайн хайлт боломжтой газарзүйн мэдээллийн систем (Веб ГМС) бөгөөд уг систем нь орон зайн дүн шинжилгээ хийдэг ArcGIS програмд суурилсан. 2-р бүрэлдэхүүн хэсэг нь геологийн мэдээллийн тухай хураангуйг хайх метадата-каталоги систем бөгөөд энэ нь орон зайн мэдээллийн каталоги хийхэд хэрэглэдэг GeoNetwork програмд суурилсан. Англи, Монгол хэл дээрхи энэхүү системийг интернетэд холбогдсон дурын хэрэглэгч ашиглах боломжтой. Монгеокат систем нь олон улсын нэр хүнд бүхий Дэлхийн гео-орон зайн форум (Geospatial world forum)-аас шалгаруулдаг "2018 оны Дэлхийн гео-орон зайн шилдэг бүтээл"-ээр шалгарсан.</p>					
	<p>3-р зорилтын хүрээнд:</p> <p>Хүрэх үр дүн 1:</p>	<p>3-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан</p> <p><b>Геологийн төв лабораторийн (ГТЛ) техникийн болон институцын чадавхид үнэлгээ хийсэн.</b></p> <p>АМЕР хөтөлбөр ГТЛ-ийн техникийн болон институцын чадавхи үнэлэх ажлыг ISO 17025 олон улсын стандарт, MNS ISO/IEC 17025-2007 Монгол улсын стандартад тулгуурлан боловсруулж, УУХҮЯ-ны Геологийн бодлогын газарт хүргүүлсэн. Үнэлгээний явцад ажил хэргийн уулзалтыг холбогдох байгууллагын төлөөлөлтэй зохион байгуулсан. Төслийн баг ГТЛ-ийн өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагааг сайжруулах талаарх зөвлөмжийг УУХҮЯ-ны Геологийн бодлогын газар болон ГТЛ-ын удирдлагад танилцуулж, хүргүүлсэн.</p>					
7.	<p>Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон ололттой тал, дутагдалтай талуудыг бичнэ.</p> <p>АМЕР хөтөлбөр нь УУХҮЯ, АМГТГ-ын тавьсан хүсэлтийн дагуу жилийн ажлын төлөвлөгөөг гарган ажилладаг нь ололттой тал болно. Анхаарах асуудал нь тухайн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгаа, тайлангуудыг ашиглах, ажил хэрэг болгох нь хамтран ажиллагч төрийн байгууллагын хариуцлагын ажил байна.</p>					
8.	<p>Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ</p>	<p>Засгийн газар хооронд байгуулсан дэд гэрээний дагуу талууд харилцан үр ашигтай ажиллаж, төслийн хэрэгжих хугацааг 1 жилээр сунгасан.</p>					
9.	<table border="1"> <tr> <td data-bbox="284 1512 592 1617">Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)</td> <td data-bbox="592 1512 722 1617">Биелэлт дундаж 93 %</td> </tr> </table>	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж 93 %	Зорилтын тоо 3	Зорилт 1 80 %	Зорилт 2 100 %	Зорилт 3 100 %
Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж 93 %						
10.	<p>Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (УУХҮЯ)</p>	<p>Нэгдсэн үнэлгээ 70%</p>					
11.	<p>(ЗГХЭГ-ын үнэлгээ)</p>						

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

(2017 оны жилийн эцсийн байдлаар )

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл						
1.	Төслийн нэр: АМГТГ-ын УУГТТЛ-ийн үйл ажиллагааг дэмжих	К-Петро төслийн зорилго нь Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, газрын тосны тосны туршилтын лабораторын үйл ажиллагааг дэмжих						
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Одоогоор өөрсдийн санхүүгийн боломжоор						
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: БНСУ-ын Газрын тосны чанар, хангамжийн газар буюу БНСУ-ын К-Петро болон Ашигт малтмал, газрын тосны газар Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:						
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Тээврийн хэрэгслийн түлшний зарцуулалтын үнэлгээ болон түлшний чанарын стандартыг сайжруулахад техник арга зүйн зөвлөгөө өгөх; Зорилт 2. Хүний нөөцийг харилцан солилцож, хамтарсан сургалт, семинарыг зохион байгуулах, мэдээлэл солилцох, лабораторийн тоног төхөөрөмж дээр ажиллах хүний нөөцийг сургах, дадлагажуулах, чадавхжуулах						
5. Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	Төсөв байхгүй						
	Үүнд:	Төсөв (он)		Гүйцэтгэл		Хувь		
	Багц 1							
	Багц 2 (г.м)							
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.						
1-р зорилтын хүрээнд:	Хүрэх үр дүн 1:	<ul style="list-style-type: none"> <li>- К-Петро байгууллагын санаачилгаар КОЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх 29 хоногийн “Practical Training for PQMS (petroleum quality management system)” сэдэвт сургалтад УУГТТЛ-ийн газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын шинжээч мэргэжилтэн Д. Дагвасүрэн хамрагдав. Тус мэргэжилтэн энэхүү сургалтын талаарх тайлан болон цаашид хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан холбогдох удирдлагад танилцуулав. Төлөвлөгөөний дагуу Монгол Улсад хийх сургалтыг зохион байгуулж, лабораторийн бэлтгэл ажлыг хангаж, ажилласан.</li> <li>- К-Петро байгууллагаас газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт, шинжилгээ, техникийн асуудал хариуцсан нэг мэргэжилтэн /багийн ахлагч-1/, шинжилгээ болон техникийн мэргэжилтэн /багийн гишүүд-2/ ирж ээлжит сургалтыг Улаанбаатар хотод 2017 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс 08 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх 10 хоногийн хугацаанд газрын тосны бүтээгдэхүүний төв лабораторид угсарч суурилуулсан шинжилгээний тоног төхөөрөмжүүд дээр техникийн сургалт зохион байгуулах ажлыг хамтран гүйцэтгэж, техникийн сургалтын явцад илэрсэн бодит нөхцөл байдлын талаар холбогдох</li> </ul>						

	удирдлагуудад танилцуулга хийсэн.				
2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 2:	Санамж бичгийн гол зорилго болох “Хүний нөөцийг харилцан солилцож, хамтарсан сургалт, семинарыг зохион байгуулах, мэдээлэл солилцох”, “Лабораторийн тоног төхөөрөмж дээр ажиллах хүний нөөцийг сургах, дадлагажуулах, чадавхжуулах” заалтыг хэрэгжүүлэхээр 2017 оны 11 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 28-ны өдрийг дуустал 14 хоногийн хугацаатай сургалтыг К-Петро Газрын тосны бүтээгдэхүүний чанар, хангамжийн газарт зохион байгуулахаар төлөвлөн, Уул уурхай, газрын тосны тосны туршилтын лабораторын 6 ажилтан дээрх сургалтанд хамрагдсан.				
7. Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Төсөл нь 2017 оны 4 сард санамж бичигт гарын үсэг зурснаар хэрэгжиж эхэлсэн байгаа бөгөөд төслийн хэрэгцээ шаардлага нь Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, газрын тосны тосны туршилтын лабораторын тоног төхөөрөмжүүдийг бүрэн ажиллагаанд оруулах, лабораторийн ажилчдыг шаардлагатай сургалтад хамруулах зэрэг Ашигт малтмал, газрын тосны газрын нэн тэргүүний шаардлагуудад нийцсэн. Одоогийн байдлаар БНСУ-ын болон Монгол Улсын Засгийн газруудаас санхүүжилт байхгүй К-Петро-ийн өөрсдийн дотоод санхүүжилтээр мэргэжилтнүүдийг БНСУ-д авчирч сургалтуудыг амжилттай зохион байгуулаад байна. Цаашдаа КОЙКА-аар дамжуулан БНСУ-ын Хөгжлийн байгууллагаас шаардлагатай санхүүжилтийг олгуулахаар төлөвлөж байна.				
8. Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	БНСУ-ын К-Петро байгууллагаас өөрсдийн нөөц бололцоо дээр тулгуурлан идэвх санаачилгатай ажиллаж байгаа.				
9. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
	80%		90%	70%	... %
10. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ УУХҮЯ	Нэгдсэн үнэлгээ				
	40 %				
11 (ЗГХЭГ-ын үнэлгээ)					

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

(2017 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл												
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	<p>Тогтвортой бичил уурхай төсөл Швейцарын Холбооны Улсын Гадаад хэргийн яамны харьяа Швейцарын хөгжлийн агентлаг болон Монгол Улсыг төлөөлж Сангийн яамны хооронд 2015 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан Тогтвортой бичил уурхай төсөл хэрэгжүүлэх хэлэлцээр</p> <p><b>Төсөл, хөтөлбөрийн зорилго:</b> Эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хувьд хариуцлагатай, хүний эрхэд суурилсан Монгол Улсын бичил уурхайн салбар нь бичил уурхайн талаарх олон улсын сайн туршлагаас суралцах, үр шимийг хүртэх, хувь нэмэр оруулах.</p>												
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Швейцарын Холбооны Улсын Засгийн газрын буцалтгүй тусламж												
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Швейцарын Хөгжлийн агентлаг болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, 5 жил (2015-2019)</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Ашигт малтмал, газрын тосны газар</p>												
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p><b>Зорилт 1. Хүний эрхэд суурилсан бичил уурхайн бодлого, бичил уурхайчдыг дэмжих:</b> бичил уурхайн оролцогч талуудын эрхийг хүндэтгэх, хамгаалах талаарх төрийн чадавхийг бэхжүүлэх, бичил уурхайчид эрхээ шаарддаг, нийгэм байгаль орчны илүү хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг болж, хүний эрхэд суурилсан хандлагыг бичил уурхайн үйл ажиллагаанд тусгасан байна.</p> <p><b>Зорилт 2. Бичил уурхайн албан ёсны борлуулалтын сүлжээний бүх оролцогч талуудын эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх:</b> Үндэсний, бүсийн, орон нутгийн эдийн засгийг бэхжүүлэх, амьжиргааг дээшлүүлэхэд оруулж буй бичил уурхайн хувь нэмэр мэдэгдэхүйц нэмэгдсэн байна.</p> <p><b>Зорилт 3. Мэдлэг харилцан солилцох, бичил уурхайн талаарх олон улсын бодлогын хэлэлцүүлгийг дэмжих:</b> бичил уурхайн оролцогч талууд үндэсний болон олон улсын сайн туршлагад хувь нэмэр оруулж, түүнээс суралцаж, нэвтрүүлнэ; Монгол Улсын хүрсэн амжилтыг үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрнө.</p>												
5.	<p>Зардал</p> <p>Төсөв (нийт шаардагдах зардал)</p> <p>Үүнд:</p> <p>Багц 1</p> <p>Багц 2</p> <p>Багц 3</p>	<p>6 сая Швейцар франк</p> <table border="1" data-bbox="553 1339 1515 1465"> <thead> <tr> <th>Төсөв (2017 он)</th> <th>Гүйцэтгэл</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>404,700</td> <td>397,015</td> <td>98.1</td> </tr> <tr> <td>528,400</td> <td>366,414</td> <td>69.34</td> </tr> <tr> <td>417,000</td> <td>348,023</td> <td>83.4</td> </tr> </tbody> </table>	Төсөв (2017 он)	Гүйцэтгэл	Хувь	404,700	397,015	98.1	528,400	366,414	69.34	417,000	348,023	83.4
Төсөв (2017 он)	Гүйцэтгэл	Хувь												
404,700	397,015	98.1												
528,400	366,414	69.34												
417,000	348,023	83.4												
6.	<p>Төсөл, хөтөлбөрийн зорилт:</p> <p>1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн:</p> <p>1. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн 50%-аас доошгүй нь албан ёсны үйл ажиллагаа явуулдаг болсон байна.</p> <p>2. Бичил уурхай бүхий сумдын 70% нь бичил уурхайн зориулалтаар</p>	<p>Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.</p> <p><b>Бүтээгдэхүүн 1.1: Хуульчлах ба албажуулах:</b> Төслийн түнш эрх бүхий байгууллагуудын шинэчлэн боловсруулсан бичил уурхайн холбогдох хууль, тогтоомжид хүний эрхийн асуудлыг тодорхой тусгасан байна.</p> <p><b>Бүтээгдэхүүн 1.1:</b></p> <p>1.1.1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг боловсронгуй болгох, бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал, боловсруулах үйлдвэрт тавигдах шаардлагыг албажуулах, бичил уурхайн асуудал хариуцсан бүтцийг бэхжүүлэх, төрийн байгууллагуудын бичил уурхайд чиглэсэн үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулахад УУХҮЯ-нд дэмжлэг үзүүлэх.</p> <p>1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн А/15 дугаар тушаалаар байгуулагдсан Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг шинэчлэн боловсруулах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж ажилласан. УУХҮЯ-ны Бодлогын</p>												



<p>ашиглах газартай болсон байна.</p> <p>3. МБУНДХ-оос хүний эрх/жендэрийн стандартад суурилсан 16 албан ёсны мэдэгдэл, хүсэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.</p> <p>4. 10 аймгийн холбогдох төрийн байгууллагууд бичил уурхайг зохион байгуулах, албажуулах ажлыг зохицуулах, бичил уурхайчдад үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг институтчилсэн байна.</p>	<p>хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Даваадоржоор ахлуулсан ажлын хэсэг бичил уурхайн үйл ажиллагаа төвлөрсөн болон хууль бус олборлолтын үйл явагдаж байгаа Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал, Төв аймгийн Заамар суманд очиж, томилолтоор ажиллахад дэмжлэг үзүүлсэн.</p> <p>2. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал боловсруулах, түүнийг туршиж ажилд дэмжлэг үзүүлж ажилласан. Аргачлал 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан дугаар А/226, А/182 тушаалаар батлагдсан.</p> <p>3. Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг сурталчлах, мэдлэг мэдээлэл түгээх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Бичил уурхайг зохион байгуулах, албажуулах гарын авлага боловсруулж 13,500 хувийг, бичил уурхайн холбогдолтой хууль тогтоомжийн эмхэтгэл гаргаж тус бүр 13,500 хувийг, Бичил уурхайчдад өгөх зөвлөмж сурталчилгааны зурагт хуудас боловсруулж 10,500 хувийг хэвлэж түгээсэн.</p> <p>4. УУХҮ-ийн сайдын 2017 оны А/131 дүгээр тушаалаар байгуулагдсан "Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам"-ын төсөл боловсруулах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Ажлын хэсгийн гишүүдийг дотоодын 21 баяжуулах үйлдвэр болон БНХАУ-ын баяжуулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцахад дэмжлэг үзүүлсэн.</p> <p>1.1.2. <i>Бичил уурхайн холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мониторинг хийх, бичил уурхайн асуудал хариуцсан бүтцийн чадавхыг бэхжүүлэхэд АМГТГ-т дэмжлэг үзүүлэх.</i></p> <p>6. АМГТГ-ын бичил уурхайн асуудал хариуцсан мэргэжилтнүүд бичил уурхайгаас олборлосон жоншны баяжуулалт, худалдааны сүлжээний талаар судалгаа хийх зорилгоор Хэнтий, Дорноговь, Дундговь аймгуудын томилолтоор ажиллахад дэмжлэг үзүүлж бичил уурхай бүхий сумдын нийт 20 баяжуулах үйлдвэр болон олборлолтын талбайд хүрч томилолтоор ажиллахад дэмжлэг үзүүлсэн.</p> <p>7. Бичил уурхайн хууль тогтоомжийг орон нутагт сурталчлах, албажуулах, зохион байгуулалтгүй хууль бус ХАМО иргэдийн үйл ажиллагааг зохион байгуулалтад оруулах, зохицуулахад орон нутгийн удирдлагуудад дэмжлэг үзүүлэх, бичил уурхайгаар олборлосон алт, гянтболдыг баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага боловсруулах, бичил уурхайгаар олборлосон ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээг албажуулах санал боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор АМГТГ-тай 99 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний санхүүжилтээр 15 аймгийн 32 суманд томилолтоор ажиллаж бичил уурхайн 86 талбайд, хууль бус олборлолтын 27 талбайд очиж бичил уурхайчид болон орон нутгийн удирдлагуудын төлөөлөл болох нийт 2,223 хүнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон эрх зүйн орчны талаар сургалт, мэдээлэл хийсэн байна. Мөн бичил уурхайн эрх зүйн орчны талаар нийт 402 байгаль орчны улсын байцаагчид сургалт явуулсан.</p> <p>8. АМГТГ-ын техникийн чадавхыг сайжруулах зорилгоор алсын жолоодлогот нисдэг төхөөрөмж буюу дрон, програм хангамжийн хамт худалдан авч өгсөн.</p> <p>1.1.3. <i>Бичил уурхайчдад хүний эрхэд суурилсан, жендерийн мэдрэмжтэй үйлчилгээ хүргэх холбогдох төрийн байгууллагын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэхэд ХЭҮК-той хамтран ажиллах.</i></p> <p>9. Хүний эрхийн үндэсний комисс бичил уурхай бүхий 6 аймгийн 17 суманд (Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Увс, Хэнтий) "Хүний эрхэд суурилсан хандлага ба Төр-иргэний харилцаа" сэдвээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж орон нутгийн удирдлагууд, мэргэжилтнүүд нийт 843 (423 эр, 420 эм) хүнд хүрч ажиллагаа. Хүрч ажилласан 843 хүний 433 (150 эр, 283 эм) нь төрийн албан хаагч, 290 (211 эр, 79 эм) зохион байгуулалтад орсон бичил уурхайчин, 71 (45 эр, 26 эм) ХАМО иргэд, 49 (17 эр, 32 эм) малчид, орон нутгийн иргэд, уул уурхайн компанийн ажилтнууд байсан.</p> <p>10. Бичил уурхай эрхлэгчид бичил уурхайн холбогдох хууль, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаа явуулахад тулгамдаж буй асуудалд хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийх, бодит нөхцөл байдалд үндэслэн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд бичил уурхайн төрийн бус байгууллагын чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн хүний эрхийн мэдлэг</p>
---	--

ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Баянхонгор, Дундговь, Сэлэнгэ, Хэнтий, Увс аймаг дахь орон нутгийн ажилтнуудын дунд "Тогтвортой бичил уурхай ба хүний эрх" жижиг тэтгэлэгт хөтөлбөрийг зарлан 2017 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ыг хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн. Тэтгэлэгт хөтөлбөрт Баянхонгор аймгийн Баян-Овоо, Өлзийт сум, Дундговь аймгийн Өлзийт, Хулд сум, Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр сум, Увс аймгийн Түргэн, Давст, Тариалан сум, Хэнтий аймгийн Хэрлэн, Батноров сумд хамрагдсан. Тус тэтгэлэгт хөтөлбөрийг орон нутгийн ахлах мэргэжилтнүүд аймгийнхаа үйлдвэрчний эвлэлийн байгууллага болон бичил уурхайн төрийн бус байгууллага, аймгийн Засаг даргын тамгын газрын Хуулийн хэлтэс, БОАЖГ, МХГ-ын төлөөлөлтэй хамтран хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн явцад холбогдох сургалт, зөвлөгөөг газар дээр нь өгч ажилласан.

11. Завхан, Өмнөговь, Өвөрхангай, Хэнтий, Ховд, Увс аймгуудад Бичил уурхайн зохион байгуулалт албажуулалтын сургалтыг зохион байгуулах ажлыг гүйцэтгэхээр сонгогдсон 6 ТББ-ын сургагч багш нар болон Хэнтий, Увс аймгийн Политехникийн коллежийн төлөөллүүд болох 18 (6 эр, 12 эм) хүнд Хүний эрхэд суурилсан хандлага, жендэрийн тэгш байдлыг үйл ажиллагаанд хэрхэн нэвтрүүлэх талаар мэдлэг, мэдээллийг ХЭҮК-оос өгсөн.
12. МБУНДХ-ны удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн гишүүд болон сургагч багш нарт 2017 оны 05 дугаар сарын 21-ний өдөр "Хүний эрхэд суурилсан хандлага", "Жендэрийн тэгш байдал ба хүний эрх", "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх", "Хүний эрхийн зөрчил болон Хүний эрхийн үндэсний Комисст гомдол гаргах журам" сэдвээр комиссын ажилтнууд сургалт зохион байгуулав. Сургалтад 18 хүн (5 эр, 13 эм) хамрагдлаа. Сургалтыг оролцооны аргаар явуулсан ба оролцогчдын зүгээс сургалтын үеэр харилцан ярилцах, асуулт асуун, мэтгэлцэх, багт хуваагдан дасгал ажиллах, бусдадаа мэдээлэл түгээх, хичээлийн сэдэвтэй холбогдуулан өөрсдийн байр сууриа чөлөөтэй илэрхийлэн оролцож, холбогдох сэдвийн хүрээнд мэдлэг мэдээлэл олж авсан.

1.1.4. 14 аймагт бичил уурхайг зохион байгуулалтад оруулах, албажуулах үйл явцыг эрчимжүүлэх, орон нутгийн түвшинд бичил уурхайн асуудлыг хариуцах, бичил уурхайчдад хүрч ажиллах бүтцийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

13. Бичил уурхайн хууль эрх зүйн орчныг сурталчлах, хариуцлагатай бичил уурхайг төлөвшүүлэх, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлыг талуудын хамтарсан санхүүжилтээр хийх, түгээн дэлгэрүүлэх, бичил уурхайн нийлүүлэлтийн сүлжээний талаар оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх, бичил уурхайгаас орон нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг дээшлүүлэх асуудлыг аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах, бичил уурхайн сайн туршлагаас судлах, бичил уурхайчид болон ХАМО иргэдэд хүрч ажиллах аймаг, сумдын төрийн байгууллагын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх зорилгоор Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Хэнтий, Дундговь, Өмнөговь, Булган, Өвөрхангай зэрэг 13 аймгийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Хамтран ажиллах гэрээний хүрээнд нийт 5,640 (3,744 эр, 1,896 эм) хүнд хүрч ажиллаад байна. Үүнээс: бичил уурхай эрхлэгчид 3,283 (2,124 эр, 1,159 эм), төрийн албан хаагч 844 (497 эр, 345 эм), ХАМО иргэд 1,599 (1,116 эр, 476 эм) иргэдэд хүрч ажиллаад байна.

**Бүтээгдэхүүн 1.2: Эрх мэдэлжүүлэх: Бичил уурхайчид, тэдний төлөөллийн байгууллагуудын эрхээ хамгаалах, шаардах, нөлөөлөх чадавхыг бэхжүүлнэ.**

1.2.1 Бичил уурхайчдын байгууллагын гишүүдийн шийдвэр гаргах үйл явц дахь оролцоо, эрх, үүрэгээ хэрэгжүүлэх чадавхыг үнэлэх, давтан судалгаа хийх.

15. "Бичил уурхайчдын байгууллагын гишүүдийн оролцоо ба нөлөөллийн ажил, оролцох эрхийн хэрэгжилт, үр дүн"-г үнэлэх харьцуулсан судалгааг дотоодын "Си Эс Ди" зөвлөх компаниар гэрээлэн (2016 оны 12 дугаар сарын 10-аас 2017 оны 4 дүгээр сарын 10 хүртэл) гүйцэтгүүллээ. Уг судалгаанд бичил уурхай нийт 23 байгууллагын 560 (347 эр, 213 эм) бичил уурхайчид хамрагдсан. Судалгааны дүнгээс харахад бичил уурхайн байгууллагын гишүүд орон нутгийн удирдлагад хандан 122 хүсэлтийг илгээхэд 91 гишүүн оролцсон ба энэ нь 2015 оны суурь судалгааны үеэс 67.2 хувиар өссөн байна. Орон нутгийн удирдлагадаа албан бичгээр хандан гаргаж байсан хүсэлтүүдийг төрлөөр нь авч үзвэл тогтмол ажлын байр буюу олборлолтын

газартай болох тухай хүсэлт (91) давамгайлах хандлага хэвээрээ ба суурь судалгааны үеэс 60.4 хувиар өсжээ. Харьцуулсан судалгааны тайланг 300 ширхэг хэвлүүлж, холбогдох талуудад түгээсэн.

*1.2.2 Бичил уурхайг зохион байгуулалтад оруулах албажуулах, гишүүдээ чанартай үйлчилгээ үзүүлэх, хүний эрхэд суурилсан хандлага, жөндөрийн тэгш байдлыг үйл ажиллагаандаа хэвшүүлэх, байгууллагын удирдлагын чадавхыг бэхжүүлэхэд нь МБУНДХ болон бичил уурхайчдын байгууллагуудад дэмжлэг үзүүлэх.*

17. МБУНДХ-г үйл ажиллагаагаа тогтвортой явуулах, бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гишүүн ТББ-уудад үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулалтгүй ХАМО иргэдэд хүрч ажиллах ажлын хүрээнд 2017 онд хийхээр төлөвлөсөн зарим үйл ажиллагааг нь хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. Үүнд:
18. МБУНДХ бүх гишүүдээ хүрч ажиллах, мэдээллийг тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор 152959 тусгай дугаар бүхий мессеж үйлчилгээ нэвтрүүлж ажилласан. Улмаар Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын талаарх мэдээллийг Мобикомын сүлжээний хэрэглэгч 578 гишүүнд шинэчлэгдэн батлагдсан мессеж хэлбэрээр хүргэсэн. Мөн "Бичил уурхайн лавлах төлбөртэй утас (1900-2959)"-ийг ажиллуулж эхэлсэн.
19. МБУНДХ нь 15 аймгийн 45 сумын нийт 6,556 (3,772 эр, 2,784 эм) хүнд хүрч ажилласнаас 609 (278 эр, 331 эм) нь төрийн албан хаагчид, 2,547 (1,364 эр, 1,183 эм) бичил уурхайчид болон 3,400 (2,130 эр, 1,270 эм) нь ХАМО иргэд байлаа. Бичил уурхайн эрх зүйн орчин, хоршиж ажиллахын давуу талыг ойлгуулах сургалтыг газар дээр нь зохион байгуулсан. Дээрх 15 аймгийн 45 суманд сургалт, уулзалт зохион байгуулах ажлыг МБУНДХ-ны гүйцэтгэх алба, сургагч багш, үнэлгээний зөвлөх, жолооч зэрэг 12 хүний бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэлээ.
20. 15 аймгийн 45 суманд бичил уурхайн зохион байгуулалтад орж, МБУНДХ-ны гишүүн байгууллагаар бүртгэгдэн орон нутгийнхаа хэмжээнд нөхөрлөл, хоршооны зохион байгуулалтад орсон 67 гишүүн байгууллагын чадавхын үнэлгээг хийж, дүгнэлт холбогдох эхний сургалтуудыг зохион байгуулсан.
21. Бичил уурхайчдын өдөрлөгийг Хэнтий, Өмнөговь, Баянхонгор аймгуудад зохион байгуулж нийт 950 (372 эр, 578 эм) гаруй хүн оролцсон.
22. Бичил уурхайчдын Зөвлөлдөх уулзалт 12 дугаар сарын 8-9-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдлаа. Тус уулзалтад 12 аймгийн 27 сумын 50 гаруй бичил уурхайн байгууллагын төлөөлөл болох 126 (62 эр, 64 эм) бичил уурхайчид оролцсон. Бичил уурхайчид өөрсдийнхөө болон МБУНДХ-ны 2016 оны ажлын гүйцэтгэл, үр дүнгээ хэлэлцэж, 2018 оны холбооны ажлын төлөвлөгөөний төсөлд саналаа өгсөн.
23. Нийгэм эдийн засаг, хүний нөөцийн Соёмбо академийн "Манлайлал, хувь хүний өөрчлөлт" 5 өдрийн вакумжуулсан сургалтад 25 (12 эрэгтэй, 13 эмэгтэй) бичил уурхайчдыг хамрууллаа. Сургалт 12 дугаар сарын эхний долоо хоногт Улаанбаатар хотод зохион байгуулагдсан.

*1.2.3. МБУНДХ-ны үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад шаардлагатай чадавхыг бий болгох зорилгоор хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, стратеги төлөвлөгөө боловсруулах.*

25. Судалгаа, зөвлөх үйлчилгээний "Эс Ай Си Эй" (SICA) ХХК нь МБУНДХ-ны байгууллагын өнөөгийн чадавхад хөндлөнгийн үнэлгээ хийж, цаашдын тогтвортой байдлыг бэхжүүлэх, чадавхыг сайжруулах талаар зөвлөмж, 4 жилийн стратеги төлөвлөгөөний санал боловсруулсан. Уг зөвлөх үйлчилгээг 2017 оны 1 дүгээр сарын 9-өөс 2 дугаар сарын 9-ний хооронд гэрээлэн гүйцэтгүүлсэн. МБУНДХ нь зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч байгууллагатай хамтран боловсруулсан стратеги төлөвлөгөөнд үндэслэн 2017 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө гарган, өгсөн зөвлөмжийн дагуу байгууллагынхаа дотоод зохион байгуулалт, манлайлал, хүний нөөц, санхүүгийн менежментийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажилласан.

*1.2.4. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдэд хүрч ажиллах, зохион байгуулалтад оруулах, албажуулалтын хүрээг тэлэх чиглэлээр орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) болон орон нутгийн төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих.*

26. Бичил уурхайн хууль тогтоомжийг сурталчлах, бичил уурхайн зохион байгуулалт, албажуулалтын чиглэлийн сургалтыг орон нутагт зохион

байгуулах, төрийн байгууллагууд, бичил уурхайчдын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор 6 аймагт (Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Ховд, Хэнтий, Увс) иргэний нийгмийн байгууллагуудыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан хамтран ажилласан. Гэрээт ажлын хүрээнд Увс аймгийн Байгаль орчин, Уул уурхайн холбоо тус аймгийн 6 сумын хэмжээнд бичил уурхайн хууль эрх зүйн орчин, хүний эрх, нийгмийн даатгалд хамрагдахын давуу тал зэрэг чиглэлээр нийт 1,382 (1,000 эр, 382 эм) хүнд үүнээс 232 (144 эр, 88 эм) төрийн албан хаагчид, 736 (556 эр, 180 эм) бичил уурхайчин болон 414 (300 эр, 114 эм) ХАМО иргэдэд хүрч ажилласан байна. Ховд аймгийн "Ажил олгогч эздийн Бадрал холбоо" тус аймгийн 6 сумын хэмжээнд 1,018 (880 эр, 138 эм) үүнээс 136 (71 эр, 65 эм) төрийн албан хаагчид, 103 (81 эр, 22 эм) бичил уурхайчин болон 779 (728 эр, 51 эм) ХАМО иргэдэд хүрч ажилласан. Хэнтий аймгийн Ажил олгогч эздийн холбоо ТББ нь тус аймгийн 6 сумын хэмжээнд 810 (502 эр, 308 эм) үүнээс 231 (118 эр, 113 эм) төрийн албан хаагчид, 356 (239 эр, 117 эм) бичил уурхайчин болон 223 (145 эр, 78 эм) ХАМО иргэдэд (давхардсан тоогоор), мөн Завхан аймгийн "Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн Завхан салбар" ТББ Дөрвөлжин, Ургамал, Завханмандал сумдад хүрч нийт 350 (235 эр, 115 эм), бичил уурхайчид 129 (83 эр, 46 эм), төрийн албан хаагчид 78 (25 эр, 53 эм), ХАМО иргэд 143 (101 эр, 42 эм), Өвөрхангай аймгийн "Амьдрал цагираг" ТББ нийт 919 (644 эр, 115 эм), бичил уурхайчид 129 (83 эр, 46 эм), төрийн албан хаагчид 78 (25 эр, 53 эм), ХАМО иргэд 143 (101 эр, 42 эм), Өмнөговь аймгийн "Өмнөговь аймгийн бичил уурхай эрхлэгчдийн холбоо" нийт 1,089 (760 эр, 329 эм), бичил уурхайчид 136 (106 эр, 30 эм), төрийн албан хаагчид 201 (119 эр, 82 эм), ХАМО иргэд 752 (609 эр, 143 эм) иргэдэд тус тус хүрч ажилласан байна.

27. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан бичил уурхайн хууль тогтоомжийг сурталчлах, бичил уурхайг хуулийн хүрээнд хэрхэн зохион байгуулах, албажуулах чиглэлийн сургалтыг орон нутагт зохион байгуулах гэрээт хамтрагч талуудад тус журмыг танилцуулах сургалт, семинарыг 2017 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Уг семинарт 6 аймгийн иргэний нийгмийн байгууллагууд болон МБУНДХ-ны Удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх алба, сургагч багш нарын төлөөлөл болсон 38 (13 эр, 25 эм) хүн оролцож бичил уурхайн шинэчлэгдсэн журмын талаар болон нөхөрлөл, хоршооны хуулийн талаар мэдээлэл авсан. Тус 6 ТББ-ын төлөөллүүд нийт 4 удаагийн сургалт, зөвлөгөөнд хамрагдаж бичил уурхайн талаарх мэдээлэл, зөвлөгөөг авч ажилласан.

**Бүтээгдэхүүн 1.4: Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал ба тэгш эрх: Ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн халамж, хамгааллыг сайжруулах талаарх холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг дэмжинэ.**

*1.4.1. Бичил уурхайчдын эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, бүртгэлийн нэгдсэн системд бүртгэх, бичил уурхайчдад эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний талаарх мэдлэг мэдээлэл түгээхэд нь ЭМНДЕГ-т дэмжлэг үзүүлэх.*

28. 2017 оны 05 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд "Нийгмийн даатгалын эрх зүй - Бичил уурхай" сэдэвт сургалтад бичил уурхай бүхий 45 сумын нийгмийн даатгалын 62 (10 эр, 52 эм) байцаагчийг хамруулж, бичил уурхай эрхлэгчдийн онцлогт тохирсон сургалтын арга барилыг нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудад эзэмшүүлэх, бичил уурхайчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулав. Аймгуудын ЭМНДХ-ээр дамжуулан бичил уурхайчдад эрүүл мэнд, нийгмийн даатгалын ач холбогдол, хамрагдалтын талаарх сургалтуудыг зохион байгуулсан.
29. Эрүүл мэндийн даатгалын бүртгэлийн нэгдсэн системд "Бичил уурхай эрхлэгч" гэсэн сонголтыг оруулах зорилгоор Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд "Бичил уурхай эрхлэгч" гэсэн даатгуулагчийн төрлийг нэмж, бичил уурхай эрхлэгч иргэдийг мэдээллийн санд ялган бүртгэх зорилгоор бүх нэгжид 009999995 дугаартай "Бичил уурхай эрхлэгч" ажил олгогчийн бүртгэлийг 2017 оны 4 дүгээр сард нэмж орууллаа.
30. Бичил уурхайчдад зориулсан "Нийгмийн даатгалд хэрхэн хамрагдах вэ?" гарын авлага, сайн дурын даатгал, эрүүл мэндийн даатгалын талаарх тараах материал боловсруулан (нийт 11,000 ширхэг) хэвлүүлж аймаг,

сумдын байцаагч нарт орон нутагт бичил уурхайчдад хүрч ажиллахад нь зориулж хэвлүүлж өгсөн.

31. МБУНДХ-ны удирдах зөвлөлийн зарим гишүүд болон сургагч багш нар нийт 20 (11 эрэгтэй, 9 эмэгтэй) хүн 2 өдрийн вакумжуулсан сургалтаар Нийгмийн даатгалын сургагч багшаар бэлтгэгдсэн.

*1.4.2. Орон нутгийн эрүүл мэндийн ажилтнуудын бичил уурхайчдад эрүүл мэндийн үйлчилгээ хүргэх, бичил уурхайн мэргэжлээс шалтгаалах өвчнийг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.*

32. ЭМЯ-аас бичил уурхай эрхлэгчдийн эрүүл мэндийн, тусламж үйлчилгээг сайжруулах, бичил уурхайчдын мэргэжлээс шалтгаалах өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг сайжруулах чадавх бэхжүүлэх багц ажлын хүрээнд бичил уурхайчид олноор төвлөрсөн Баянхонгор аймагт "Бичил уурхай эрхлэгчид болон тэдний гэр бүлийн гишүүдэд химийн бодисын хор, хөнөөлийн талаар хэрхэн сурталчлах талаар 2017 оны 6 дугаар сарын 2-3-ны өдрүүдэд сургалт зохион байгуулсан. Сургалтад бичил уурхай бүхий Баацагаан, Баян-Овоо, Баян-Өндөр, Баянбулаг, Баянцагаан, Бөмбөгөр, Галуут, Жаргалант, Жинст, Шинэжинст, Хүрээмарал, Эрдэнэцогт, Баянлиг, Гурванбулаг, Заг сумдын эрүүл мэндийн төвийн эмч нар болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч нар, Эрүүл мэндийн газрын дарга, мэргэжилтэн нийт 21 хүн (5 эр, 15 эм) оролцсон.
33. Сургалтад оролцсон эмч нар бичил уурхай эрхлэгчид болон тэдний гэр бүлийн гишүүдэд химийн бодисын хор, хөнөөлийг сурталчлах сургалтыг Баянхонгор аймгийн Галуут, Жаргалант, Заг, Гурванбулаг сумдад хийсэн. Сургалтад нийт бичил уурхайчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд болох 1,000 хүн хамрагдсан байна.
34. Бичил уурхай бүхий 13 аймгийн 40 сумын эмч, эмнэлгийн ажилтнуудыг чадавх бэхжүүлэх сургалтад хамруулсан.
35. Бичил уурхай бүхий Төв, Сэлэнгэ, Баянхонгор аймгийн 1,000 бичил уурхайчныг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

*1.4.3. Бичил уурхайчдад үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулахад ХХҮЕГ-т дэмжлэг үзүүлэх.*

36. Бичил уурхай бүхий аймаг, дүүргийн Зорилтот өрхийн хөгжил, хөтөлбөрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтнүүдийн чадавх бэхжүүлэх сургалтыг 2017 оны 05 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд зохион байгууллаа. Уг сургалтад нийт 30 (9 эр, 21 эм) мэргэжилтэн оролцлоо. Сонгогдсон 5 аймгийн (Дундговь, Өвөрхангай, Хэнтий, Ховд, Төв) 10 суманд бичил уурхайчдад зориулсан сургалт зохион байгуулагдаж нийт 550 (385 эрэгтэй, 165 эмэгтэй) бичил уурхайчин хамрагдсан.
37. Зорилтот өрхийн үнэлгээг хийдэг аргачлал шинэчлэгдсэнтэй холбогдуулан зорилтот бүлгийн иргэдтэй ажилладаг нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлагыг шинэчлэн боловсруулж, 300 ширхгийг хэвлүүлж сургалтдаа ашигласан. Мөн зорилтот бүлгийн иргэдэд (бичил уурхайчдад) зориулсан 14 төрлийн нугалбарыг боловсруулан 8,000 ширхгийг хэвлүүлэн түгээсэн. (Үүнд: Орон сууц, газар өмчлөл, Эрүүл ахуй, аюулгүй байдал, Хүнсний хэрэглээ, Хүнсний бус хэрэглээ, Өрхийн санхүү, Өрхийн ажил, эрхлэлт, Эрүүл мэндийн хэрэгцээ, Эрүүл мэндийн хяналт, үйлчилгээ, Сургуульд хамрагдалт, Мэдээлэл, харилцаа холбоо, Нийгмийн халамж, Нийгмийн даатгал, Гэр бүлийн харилцаа, Нийгмийн харилцаа)
38. Бичил уурхай бүхий зарим аймгийн сонгогдсон сумдын өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд хамрагдсан бичил уурхай эрхлэгч гишүүнтэй өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар амьжиргааг нь дээшлүүлэх жижиг төслүүдийг (1 сая төгрөг хүртэлх жижиг төсөл) сонгогдсон 5 аймгийн 10 суманд хэрэгжүүлсэн. Уг төсөлд бичил уурхайчин 13 өрх хамрагдсан.
39. Дундговь аймгийн бичил уурхай бүхий Хулд, Өлзийт сум, Хэнтий аймгийн Батноров, Норовлин, Өвөрхангай аймгийн Уянга, Төв аймгийн Заамар, Борнуур сумдын хэмжээнд өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж буй ажлын явцыг үнэлэх, мониторинг хийх, зарим өрхийн болон сумын хэмжээнд хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, нэгтгэлийн байдалтай танилцан, зөвлөмж чиглэлээр хангах ажлыг зохион байгуулсан Хэрэгжилтийн явцтай танилцахад "Бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй", "Амьдралын итгэл үнэмшил болон гэр бүлийн боловсрол олгох нь" сэдвүүдийн хүрээнд дээрх сумдын нийт бичил

	<p>уурхайчин 350-аад бичил уурхайчин өрхийг хамруулсан 2 өдрийн сургалтыг хийж дууссан байна.</p> <p>1.4.4. Бичил уурхайчдад осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах, ХАБЭА-г сайжруулах, авран туслах үйлчилгээ үзүүлэх боловсон хүчний чадавх, тогтолцоог бэхжүүлэхэд нь ОБЕГ, ХНХЯ-нд (ХАБЭА-н дэд хороо) дэмжлэг үзүүлэх.</p> <p>40. ХНХЯ-ны багц ажлын хүрээнд 21 аймаг, нийслэлийн 3 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн ХАБЭА-н асуудал хариуцсан 56 (16 эр, 40 эм) мэргэжилтнийг хамруулан бичил уурхайн эрх зүйн орчин, бичил уурхайн ХАБЭА-ны талаар чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулсан.</p> <p>41. Бичил уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрмийн төслийн боловсруулахад оролцож, хамтарч ажилласан. Тус дүрмийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан 2017 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн А/115, А/123 дугаар тушаалаар баталсан. Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой хууль тогтоомжийн эмхэтгэлд оруулж 1,000 хувь хэвлүүлж түгээсэн. Бичил уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм"-ийг сурталчлах, мөрдөж хэрэгжүүлэх зорилгоор комикс хэлбэрийн зурагт сурталчилгааны хуудсыг 400 ширхгийг хэвлүүлж, түгээсэн.</p> <p>42. ХНХЯ бичил уурхайчид олноор төвлөрсөн Говь-Алтай аймгийн Бигэр, Есөнбулаг сумдад ажиллаж суманд бичил уурхай эрхэлж байгаа иргэд, хоршоо, нөхөрлөлийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаатай танилцаж шинээр батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, Бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийг танилцуулж, сургалт зохион байгуулсан. Сургалтад 65 (45 эрэгтэй, 20 эмэгтэй) хүн хамрагдсан.</p> <p>43. ОБЕГ-ийн харьяа УУАА-ны сургалтын баг тухайн аймаг, дүүргийн Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран Налайх, Багахангай дүүрэг, Хэнтий аймгийн Батноров, Баян-Адарга, Норовлин сумд, Бор-Өндөр, Бэрх тосгон, Өмнөговь аймгийн Цогт-Овоо, Баяндалай, Сэврэй, Даланзадгад сумд, Дундговь аймгийн Хулд, Мандалговь, Гурвансайхан, Баянжаргалан сумд, Төв аймгийн Заамар, Борнуур сумд, Булган аймгийн Бүрэгхангай сум, Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Мандал, Ерөө, Баянгол сумд, Дархан-Уул аймгийн Шарын гол сум, Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан сумд, Өвөрхангай аймгийн Уянга сум, Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бөмбөгөр, Галуут, Жаргалант сум, Говь-Алтай аймгийн Алтай, Есөнбулаг сумд, Ховд аймгийн Цэцэг, Үенч, Булган сумд, Увс аймгийн Өмнөговь, Тариалан сумд, Архангай аймгийн Цэнхэр сумд, Завхан, Сүхбаатар, Дорнод аймгуудад нийт 50 удаагийн ХАБЭА-н сургалт зохион байгуулж ажилласан. Нийт 17 аймгийн аймгийн 34 сум, 3 баг, нийслэлийн 2 дүүрэгт зохион байгуулсан сургалтад нийт 5,824 хүн (4,680 эр, 510 эм) үүнээс 5,190 бичил уурхайчин, 577 орон нутгийн төрийн албан хаагчид болон 521 аймгийн Онцгой байдлын газрын аврагч нар хамрагдсан.</p> <p><b>Бүтээгдэхүүн 1.5: Өргөдөл гомдол ба маргаан шийдвэрлэлт: Хүний эрх, ашигт малтмал, өмчийн эрхийн зөрчил, маргааныг шийдвэрлэх аргачлалыг олон улсын гэрээ, сайн туршлагад нийцүүлэн бүрдүүлнэ.</b></p> <p>1.5.1. Өргөдөл, гомдол, зөрчил, маргааныг шийдвэрлэх аргачлалыг боловсруулж, хэвлүүлж тараах.</p> <p>44. "Бичил уурхай дахь өргөдөл, гомдол, зөрчил, маргааныг шийдвэрлэх нь - иргэдийн хөтөч" бичил уурхайчдад зориулсан гарын авлагыг ХЭҮК-той хамтран боловсруулж 3,000 ширхгийг хэвлүүлж түгээсэн.</p>
<p>2-р зорилтын хүрээнд:</p> <p>Хүрэх үр дүн :</p> <p>1.Орон нутагт бичил уурхайгаар олборлосон ашигт малтмалын худалдааг албажуулах хүний эрхэд суурилсан</p>	<p><b>Бүтээгдэхүүн 2.1: Нийлүүлэлтийн сүлжээг албажуулах: Бичил уурхайн нийлүүлэлтийн албан ёсны сүлжээний эрх зүйн болон санхүүгийн тогтолцооны хэлбэр, хэрэгцээний талаар холбогдох талууд зөвшилцөлд хүрсэн байх</b></p> <p>2.1.1. Алтны худалдааны сүлжээг албажуулах бодлогын хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, бичил уурхайгаар олборлосон алтны худалдаалах сүлжээг албажуулах үндэсний бодлого гаргахад дэмжлэг үзүүлэх</p> <p>45. Алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд бусад орны сайн туршлагаас суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор УИХ-ын гишүүд, УУХҮЯ, АМГТГ, Монголбанк, ҮМСХГ-ын төлөөллийг оролцуулан</p>

<p>хууль, эрх зүйн орчинг бий болгоход дэмжиж ажиллана.</p> <p>2. Төвлөрсөн бус алтны борлуулалтын сүлжээг албажуулах санаачлага, хөтөлбөрүүдийг туршсан байна.</p> <p>3. Хариуцлагатай борлуулалтын сүлжээний санаачлагуудыг дэмжиж, бичил уурхайн байгууллагуудад 2017 онд 1-ийг нэмж нэвтрүүлсэн байна.</p> <p>4. 2017 онд багадаа 10 эмэгтэй, эрэгтэй албажсан бичил уурхайчдыг нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлд хамруулсан байна.</p> <p>5. 2017 онд бичил уурхайгаар олборлосон алтны хэмжээ 4 тонн хүртэл буюу жилдээ 2 тонноор өссөн байна.</p> <p>6. Бичил уурхайгаас олсон орлогынхоо тодорхой хэсгийг өөр бизнест оруулж буй бичил уурхайчид, алтны худалдаачдын тоо багадаа 174-т (30%-аас доошгүй нь эмэгтэй) хүрсэн байна.</p> <p>7. 4-өөс доошгүй аймаг бичил уурхайгаас орон нутгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг хүлээн зөвшөөрч, бичил уурхайг бодлогоор дэмжсэн байна.</p>	<p>Латин Америкийн Колумб, Эквадор улсад туршлага судлах арга хэмжээг 2017 оны 10 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөж бэлтгэл ажлыг хангасан боловч Засгийн газар солигдсонтой холбоотойгоор хойшлуулж 2018 онд хийхээр төлөвлөлөө.</p> <p>46. Монгол Улсын алтны нийлүүлэлтийн сүлжээний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, олон улсын туршлагуудтай харьцуулсан судалгаа хийж шийдвэрлэх гарцууд, боломжит бодлогын хувилбарыг санал болгосон олон улсын шинжээчийн тайланг эцэслэн холбогдох газруудад хуваалцан санал солилцлоо.</p> <p>2.1.2. Алтны борлуулалтын нэг цэгийн үйлчилгээг турших, жонш, гянтболдын борлуулалтын сүлжээг сайжруулах санал боловсруулах, МБ болон ҮМСХГ-ыг алтны борлуулалтын сүлжээний сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.</p> <p>47. Алт-2 үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, алтны нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашигтай байдлыг дээшлүүлэх, бичил уурхай эрхлэгчдэд илүү үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх, тэдгээрийн улс орны макро эдийн засагт илүү их хувь нэмрээ оруулах боломжийг бий болгох зорилгоор Стандарт, хэмжил зүйн газрын Үнэт металлын сорьцын хяналтын газар, Монголбанк, Татварын ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэн бичил уурхайчдад алтны нийлүүлэлтийн албан ёсны сүлжээний талаарх сургалт зохион байгууллаа. Сургалтад Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Увс, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Хэнтий аймгуудын 25 сумын 945 бичил уурхайчин (613 эр, 332 эм), бичил уурхайн байгууллагууд (ТББ), орон нутгийн засаг захиргааны ажилтнууд (татварын байцаагч, хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан), Монголбанкны орон нутгийн ажилтнууд зэрэг нийт 76 (64 эр, 12 эм) төрийн албан хаагч хамрагдсан байна. Сургалтаас гарсан санал зөвлөмж дүгнэлтийг төслийн болон төрийн байгууллагуудын цаашдын үйл ажиллагаанд тусган ажиллахаар төлөвлөж байна.</p> <p>48. Нэг цэгийн үйлчилгээний төвийг бичил уурхай төвлөрсөн орон нутагт байгуулж алт сорьцлох, худалдан авах төвлөрлийг сааруулах, холбогдох дүрэм журмын өөрчлөлтийг боловсруулан мөрдүүлэх талаар УУХҮЯ-ны бодлогын хэрэгжилтийг хангах газартай хамтран ажиллаж байна. Энэ асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр УУХҮЯ, АМГТГ, СЯ, Монголбанк, ТЕГ, СХГ хамтарсан ажлын хэсэг байгуулахаар УУХҮЯ-аас шийдвэрлэлээ. Ажлын хэсгийн эхний хурлыг 12 сард хийхээр төлөвлөж байна.</p> <p>49. Орон нутагт ҮМСХГ-ын харъяа сорьцын лаборатори байгуулах төсөлд санал өгч ажиллалаа. Зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт, хүний нөөц, урсгал зардлыг тооцон гаргаж ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэлээ.</p> <p>2.1.3. Алт-2 хөтөлбөрт тусгагдсан бичил уурхайтай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хөтөлбөрийг сурталчлан таниулахад дэмжлэг үзүүлэх.</p> <p>50. Алт-2 хөтөлбөрт тусгасан бичил уурхайтай холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагуудыг дэмжиж ажиллахаар төлөвлөж байна.</p> <p>2.1.4. Алтны нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, бичил уурхайчид болон алтны худалдаачдын орлогыг нэмэгдүүлэхэд ГОУХАН-тэй хамтран ажиллах.</p> <p>51. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран бичил уурхайчдын үр чадварыг үнэлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох судалгаа, сургалтуудыг зохион байгуулж байна.</p> <p>52. Төслийн хүрээнд Турк Улсын алтны дархан Баки Полат 2017 оны 1 сард Монголд 2 дахь удаагаа ирж, дархчуудын үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн. 2017 оны 6 дугаар сарын 14-18-ны хооронд Монголын дизайнеруудын холбоотой хамтран нийт 27 (21 эр, 6 эм) оролцогчдоос ирсэн алт, үнэт чулуугаар хийсэн бүтээгдэхүүнүүдээр гоёл чимэглэлийн үзэсгэлэн гаргасан бөгөөд тэмцээний ялагчид болон багш нарын бүрэлдэхүүнтэй 10 хүн (5 эр, 5 эм) 12 дугаар сарын 3-14 -нд ХБНГУ-д уран дарханы мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдлаа.</p> <p>53. Уг төслийн хүрээнд 2017 оны эхний улиралд УУХҮЯ-тай хамтран дугуй ширээний уулзалт зохион байгуулж, алтны нийлүүлэлтийн сүлжээний</p>
---	---

- талаар дэлгэрэнгүй хэлэлцлээ. Энэхүү хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжүүдийн дагуу талууд хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.
54. Ражив Гандийн нэрэмжит мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн политехникийн коллежид иж бүрэн тоноглогдсон уран дарханы ангийг бий болгохоор тоног төхөөрөмжүүд худалдан авсан бөгөөд 2018 оны 1 дүгээр сард хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.
55. Уран дарханы сургалтын хөтөлбөрийг олон улсын туршлага бүхий багш нартай хамтран боловсруулж байна.
56. 2017 оны 11 дүгээр сарын 20-21-нд Баянхонгор аймагт уран дарханы анхан шатны сургалтыг 15 бичил (14 эр, 1 эм) уурхайчдад зохион байгууллаа. Оролцогчдод металл давтах, уяраах, хайлуулах, гагнах, хуурайдах, хөрөөдөх, өнгөлөх зэрэг үйлдлүүдийг зааж дадлага ажлаар бөгж, ээмэг, зүүлт зэрэг бүтээгдэхүүн хийлгэсэн байна. Сургалтад хамрагдагсдаас 10 бичил уурхайчныг сонгон шалгаруулж Улаанбаатар хотод ахисан шатны сургалтад хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.

**Бүтээгдэхүүн 2.2. Нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдал: Бичил уурхайчид албан ёсны, хариуцлагатай, эдийн засгийн хувьд ашигтай нийлүүлэлтийн сүлжээнд нэгдсэн байх**

*2.2.1. Бичил уурхайчдад татвар, түүний ач холбогдлыг ойлгуулах сургалт зохион байгуулахад ТЕГ-т дэмжлэг үзүүлэх.*

57. Энэхүү үйл ажиллагааг 26 дугаарт дурдсан үйл ажиллагааны хүрээнд хамтатган зохион байгуулсан болно. Хамтарсан сургалтын үйл ажиллагааны үндсэн зорилго нь төрийн 3 байгууллагын (ҮМСХГ, ТЕГ, Монголбанк) нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудад (бичил уурхай эрхлэгчид болон худалдаа эрхлэгчдэд) харилцан ашигтай, үр дүнтэйгээр хүрч үйлчлэх чадамжийг нэмэгдүүлэх, бичил уурхай эрхлэгчдийн алтаа сорьцлуулах, албан ёсны худалдан авагчдад хэрхэн борлуулах болон тэдний татварын эрх зүйн орчны мэдлэгийг нэмэгдүүлснээр алтны албан ёсны нийлүүлэлтийн сүлжээгээр дамжих алтны хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэж ажиллалаа. Цаашид төслийн хүрээнд ТЕГ-тай хамтран орлогын албан татвар төлөгч бичил уурхайчдын тоог нэмэгдүүлэх, төлсөн татварыг жендерийн мэдрэмжтэйгээр бүртгэлжүүлэх ажлыг хийхээр төлөвлөж байна.
58. МБУНДХ-ны сургагч багш нарт (нийт 21 багш - 5 эр, 16 эм) аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан гаргах сургалтыг зохион байгуулаа. Сургалтаар татварын онолын түвшний мэдлэгийг бататгаж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль хэрэглээний онцлог, татвар ногдуулах орлогыг тодорхойлох аргачлал, татварын хувь хэмжээ, ногдуулалт, төлөлт, тайлагналтын талаар жишээ, баримтаар тайлбарлав. Татварын тайлан гаргах үйл ажиллагааг e-tax.mta.mn систем дээр онлайн хэлбэрээр жишээгээр зааварчилгаа өглөө.

*2.2.2. Бичил уурхайг албажуулах, хариуцлагажуулахтай холбоотой сургалтуудын үр дүнд судалгаа хийх.*

59. Төслийн хүрээнд бичил уурхайг албажуулах, хариуцлагажуулахтай холбоотой чадавч бэхжүүлэх сургалтуудын үр дүнд мониторингийн үнэлгээ хийх зорилгоор уг судалгааны ажлыг Эс Ай Си Эй судалгааны компаниар гэрээлэн гүйцэтгүүллээ. Судалгаанд нийт 770 бичил уурхайчин оролцсон бөгөөд судалгааны үр дүнд ТБУТ-ийн хүрээнд зохион байгуулагдсан сургалтууд ойлгомжтой байдал болон ач холбогдлын хувьд дунджаар 4.4 оноогоор сайн үнэлгээтэй гарсан ба МСҮТ-ийн сургалт 5 онооноос 4.6 оноогоор хамгийн өндөр үнэлэгдсэн байна. Түүнчлэн тус судалгааны үр дүнгээс харахад бичил уурхайн салбарт оролцогч талуудын дунд мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх сургалтууд болох МСҮТ, Хуримтлалын бүлгийн сургалт, Манлайллын болон Бизнесийн сургалтууд дундаж онооноос дээш үнэлгээг авч маш ойлгомжтой буюу тэр хэмжээгээрээ хүртээмжтэй байжээ. Энэ нь тухайн сургалтын агуулга бичил уурхайчдын өнөөгийн амьдралд хэрэгцээ шаардлага өндөртэй байсантай холбоотой гэж дүгнэж байна. Судалгаанд оролцогчдын 67 хувь нь сургалтын хэрэгцээ, ач холбогдлыг маш хэрэгтэй цаг үеэ олсон, ач холбогдолтой сургалт байсан гэж үнэлсэн байна. Бичил уурхайчдын цаашдын сургалтын хэрэгцээ "Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сургалт", "МСҮТ-н мэргэжил олгох/мэргэшүүлэх сургалт"-ууд 27 хувь, 36 хувьтай тус тус тодорхойлогдсон байна. Нийт судалгаанд оролцогчдын 90% нь сургалтаар олж авсан мэдлэгээ бусадтай хуваалцдаг гэж байгаа нь бичил уурхайчдын



сургалт нь мэдлэг, мэдээлэл түгээх нэг үндсэн суваг болж байгааг харуулж байна.

*2.2.3. ҮМСХГ-ын техникийн хүчин чадлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх: аналитик жин, XRF машин (2.1.4 ажилтай уялдуулах)*

60. ҮМСХГ-ийн техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Итали Улсад үйлдвэрлэсэн 3 кг хүртэлх жинтэй алт хайлуулах 40 сая төгрөгийн өртөг бүхий индукцийн зуухыг хөргөлтийн төхөөрөмжийн хамт худалдан авч суурилуулж өгсөн. Энэхүү зуухыг хүлээлгэн өгөх ёслолын үйл ажиллагааг 2007 оны 3 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан ба Монгол Улсын Шадар сайдын ажлын алба, Стандарт хэмжилзүйн газар, Швейцарийн хөгжлийн агентлаг зэрэг холбогдох байгууллагуудын төлөөллүүд оролцлоо. Бага хэмжээний алт хайлуулах боломжтой энэхүү зуухыг ашиглалтад оруулснаар бичил уурхайчид болон хувиараа ашигт малтмал олборлогч иргэд ҮМСХГ-аар түргэн, шуурхай үйлчлүүлэх боломжтой болж байна.

61. ТБУТ-аас ҮМСХГ-ын үйлчилгээний чанарыг улам сайжруулахад дэмжлэг үзүүлэх үүднээс өндөр нарийвчлал бүхий алт сорьцлох, жинлэх төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэхээр нийлүүлэгч байгууллагыг сонгон худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байна. 2018 оны 1 дүгээр сард 2 ширхэг алтны дээж жинлэх төхөөрөмжийг ҮМСХГ-т хүлээлгэн өгнө.

*2.2.4. Хамтарсан санхүүжилттэй бичил уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг түгээн дэлгэрүүлж, нөхөн сэргээлт хийхэд орон нутгийн төрийн байгууллагын ажилтнууд, бичил уурхайчдын оролцоо, чадавхыг бэхжүүлэх.*

62. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу Баянхонгор аймгийн Галуут сумын Шар хуруу нэртэй газар 5 га, Баян-Овоо сумын Цагаан цахирт нэртэй газар 3.5 га, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Рашаантын шил 1 га, Баяншанд жамбий 3.8 га, Зүрх толгойн урьд салаа 6.2 га нийт 11 га, Ховд аймгийн Алтай сумын Бодончийн хөндлөнгийн Тамт нэртэй газар 5 га, Увс аймгийн Хяргас, Түргэн, Өмнөговь, Тариалан сумдад нийт 8 га, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Могойн гол нэртэй газар 5 га эвдэрсэн талбайд нийт 37.5 га талбайд тухайн орон нутгийн бичил уурхайн 10 ТББ-уудын оролцоотойгоор нөхөн сэргээлт хийлээ. Нөхөн сэргээлтэд орон нутгийн төсвөөс 29.5 сая, бичил уурхайн байгууллагуудаас 17.0 сая төгрөгийн хамтарсан санхүүжилт оруулсан бөгөөд төслөөс 100 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

63. Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу хэрхэн нөхөн сэргээлт хийх талаар чадавх бэхжүүлэх, сургалт явуулах, практик дадлага хийлгэх ажлыг Тогтвортой хөгжилд талуудын оролцоо ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлсэн. Үүнд: Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын сургалтыг Сэлэнгэ аймгийн Ерөө, Баянхонгор аймгийн Баян-Овоо, Увс аймгийн Хяргас, Түргэн сумдад зохион байгуулж нийт 98 (58 эр, 40 эм), төрийн албан хаагч 28 (19 эр, 9 эм), бичил уурхай эрхлэгч 70 (39 эр, 31 эм) иргэд хамрагдсан.

*2.2.5. Алт болон гянтболдын боловсруулах цехийн техникийн шаардлагуудыг сайжруулах, боловсруулах цехүүдэд байгаль орчны аудит хийхэд дэмжлэг үзүүлэх (1.1.2 ажилтай уялдуулах)*

64. УУХҮЯ дээр байгуулагдсан баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх журам, техникийн шаардлага боловсруулах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Эхний байдлаар журмын төслийг холбогдох талуудад танилцуулах хэлэлцүүлэг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.

65. БОАЖЯ-нд Сэлэнгэ аймгийн Мандал суманд байрлах "Мандал хишиг хайрхан" ОНӨААТҮГ, "Сүрлэг мандал" хоршоо Баянхонгор аймгийн Баян-Овоо суманд байрлах Хонгорын хүдэр ХХК-ийн Бичил уурхай эрхлэгчдийн алтны баяжуулах үйлдвэрүүдэд байгаль орчны аудит хийхэд дэмжлэг үзүүлсэн.

**Бүтээгдэхүүн 2.3. Эдийн засгийн сонголт ба эрх чөлөө: Уул уурхайтай холбоотой төрөл бүрийн бизнесийн загваруудыг бичил уурхайн ТББ-уудад хүргэсэн байх**

*2.3.1. Бичил уурхайгаас олсон орлого, өөрийн хөрөнгө оруулалтаар өөр төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь бичил уурхайчид, худалдаачдад дэмжлэг үзүүлэх.*

66. Төслийн хэрэгжиж байгаа орон нутгууд дахь албан ёсоор бүртгэгдсэн бичил уурхайчдад хөдөөгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулагч, эдийн засгийн дэд салбарын хариуцлагатай гишүүд болоход нь туслах, үр ашигтай, хариуцлагатай бичил уурхайн бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор жижиг зээл олгох үйл ажиллагааг Вишнфанд болон Капмон ББСБ-уудтай хамтран зохион байгуулж байна. Төслийн хугацаанд нийт 31 жижиг зээл олгохоор төлөвлөснөөс тайлант хугацаанд 25 зээлийн 79.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. Бичил уурхайчид зээлийн хөрөнгөөр жижиглэн худалдаа-13, машин засвар-1, газар тариалан-1, оёдол-2, эсгий үйлдвэрлэл-2, гутал үйлдвэрлэл-1, мужааны цех-1, бетон хашаа үйлдвэрлэл-1, модны худалдаа-1, зургийн газар-1, мал аж ахуй-1 зэрэг бизнес эрхэлж байна. Жижиг зээлийн хөтөлбөрийн үр дүнд бичил уурхайчид бизнесийн эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх болон бизнесийн үйл ажиллагааныхаа ашиг орлогоо нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний чанараа сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгийг худалдан авч санхүүжүүлэх боломжтой болсон.

*2.3.2. Бичил уурхайчдын байгууллагыг Шударга олборлолтын стандартын шаардлагыг хангах, олон улсын зах зээлд алт экспортлоход нь дэмжлэг үзүүлэх, шинээр Шударга олборлолтын гэрчилгээ авах бичил уурхайчдын байгууллагыг дэмжих.*

67. Шударга олборлолтын (ШО) стандартын талаарх мэдлэг мэдээллийг бичил уурхайчдын төрийн бус байгууллагуудын удирдлага, гүйцэтгэх албаны ажилтнуудад өгөх зорилгоор Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран 1 өдрийн сургалт зохион байгууллаа. Сургалтад бичил уурхайчдын ТББ-ууд, Тогтвортой бичил уурхай төсөл, МБУНДХ-ны төлөөлөл бүхий 15 (6 эр, 9 эм) хүн оролцсон. Сургалт явуулснаар оролцогчдын хариуцлагатай бичил уурхай болон ШО-ын стандартын талаарх мэдлэг мэдээлэл сайжирсан ба сургалтын явцад стандартын анхан шатны ерөнхий шалгуур үзүүлэлтээр удирдлага, удирдах албан тушаалтнууд өөрсдөө ТББ-ынхаа ерөнхий нөхцөл байдлыг үнэлж үзэхэд сургалтад хамрагдсан бичил уурхайн ТББ-уудаас 5 нь анхан шатны шалгуур үзүүлэлтүүдийг 60%-тай хангаж байна.

68. Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ХАМОДХ ТББ нь 2015 онд Шударга олборлолтын экологийн цэвэр алт ангилалд гэрчилгээ авснаар Монголын бичил уурхайчид ил тод, байгаль орчинд халгүй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг болохыг олон улсад баталгаажуулсан билээ. Тус ТББ жил тутам олон улсын Ай Эм О аудитын байгууллагаар үйл ажиллагаагаа хянуулж баталгаажуулан ажиллаж байна. ХАМОДХ ТББ нь Шударга олборлолтын 2017 оны ээлжит аудитын шалгалтаа 2017 оны 6 дугаар сарын 27-ноос 7 дугаар сарын 1-ны хооронд амжилттай давсан байна.

69. 2016 онд ХАМОДХ ТББ нь Хонгорын хүдэр ХХК-ийн баяжуулах цехтэй хамтран туршилтын журмаар 1 кг экологийн цэвэр алтыг АНУ-д экспортолж 6,000 ам.долларын урамшуулал авсан билээ. 2017 онд ТБУТ-өөс энэ туршлагыг дэлгэрүүлж Шударга олборлолтын алтаа олон улсын зах зээлд борлуулахад нь гэрчилгээ бүхий ТББ-д дэмжлэг үзүүлж бичил уурхайчдын орон нутгийн нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, улам илүү хариуцлагатай үйл ажиллагаа эрхлэхэд нь дэмжихээр төлөвлөн ажиллаж байна. Энэ үйл ажиллагааны хүрээнд Шударга олборлолтын алтыг худалдан авагч олон улсын агентуудтай холбоо тогтоон ажиллаж байгаа ба 2017 онд Герман улсын Трайд Гоулд компани ХАМОДХ ТББ-тай хамтран ажиллах, шударга олборлолтын эко алт худалдан авах гэрээнд гарын үсэг зурлаа. Энэхүү гэрээний хүрээнд ХАМОДХ ТББ нь нийт 6 кг эко алтыг туршилтын журмаар нийлүүлж 36,000 ам долларын (88,200,000 төгрөг) нэмэлт урамшуулал хүртсэн байна. Хариуцлагатай бичил уурхайн үйл ажиллагаа явуулсны шагналд хүртсэн энэхүү урамшууллын сангаа ХАМОДХ ТББ нь бичил уурхайчдыг хөгжүүлэх, сургах, тэдний амьдрал ахуйг сайжруулах зэрэг ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

70. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх олон улсын Шударга олборлолтын стандартыг хангах, бичил уурхайн байгууллагуудыг хөгжүүлэх зорилгоор 2017 онд 2 байгууллагыг сонгохоор төлөвлөснөөс Сэлэнгэ аймгийн Мандал суманд 1 байгууллагыг сонгон байгууллагын үнэлгээ, хөгжүүлэх болон хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, байгаль орчны чиглэлээр сургалт, зөвлөгөө өгөх үйл ажиллагаануудыг зохион байгуулж байна.

		<p>2.3.3. Бичил уурхайчдыг уул уурхайн болон бусад мэргэжил эзэмшүүлэх сургалтуудад хамруулан, тэдний орлогоо нэмэгдүүлэх санал, санаачлагыг дэмжих.</p> <p>71. Хэнтий аймгийн МСҮТ, Увс аймгийн Политехникийн коллеж болон Улаанбаатар хот дахь Ражив-Гандийн нэрэмжит Үйлдвэр Урлалын политехникийн коллежуудтай хамтран бичил уурхайчдыг мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтуудад хамрууллаа. Тайлант хугацаанд нийт 710 (562 эр, 148 эм) хүнд мэргэжил эзэмшихийн ач холбогдлын талаар сургалт явуулж, бичил уурхайчдын мэргэжлийн хэрэгцээний талаар судалгаа авч, 65 (43 эм, 17эр) хүнд мэргэжил олгох богино хугацааны сургалт явуулж төгсгөсөн, нийт 20 (14 эм, 6 эр) бичил уурхайчин нэг жилийн мэргэжил олгох сургалтад тэтгэлэгтэйгээр хамрагдаж, 2018 оны 6 дугаар сард төгсөх төлөвлөгөөтэй байна. Бичил уурхайчид нь өөрсдийн сонголтоор оёдолчин-32, гоо сайханч-5, автомашины засварчин-15, цахилгаанчин-2, нарийн бичиг-2, гар урлал-1, гагнуурчин-5, талх нарийн боов-1, барилгын дотоод засал чимэглэл-12, тогооч-2, малын эмч-3, агротехникч-1, санитар-3, мах махан бүтээгдэхүүний технологийн ажилтан-1 гэх мэт мэргэжлүүдийг сонгон суралцлаа.</p> <p><b>Бүтээгдэхүүн 2.4. Орон нутгийн эдийн засгийг бэхжүүлэх: Бичил уурхайчид болон алтны худалдаачид орон нутгийн амьдралын түвшин, эдийн засгийн нэр төрөл, тогтвортой байдлыг сайжруулахад оруулах хувь нэмрээ дээшлүүлэх чадвартай болсон байх</b></p> <p>2.4.1. Бичил уурхайчид, алтны худалдаачдыг бизнесийн санаа олох, хөрөнгө оруулалт хийх, эдийн засгаа солонгоруулах чадавхыг дээшлүүлэх.</p> <p>72. Бичил уурхайчдыг уул уурхайгаас өөр бизнес эрхлэх чадавхыг нь бэхжүүлэх зорилгоор МБУНДХ-той хамтран Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл" хөтөлбөрийн 8 сургагч багш (2 эр, 6 эм) бэлтгэсэн. Эдгээр сургагч багш нараар дамжуулан бизнесийн төсөл бичих, жижиг бизнес эрхлэх арга зүйд сургах сургалтыг бичил уурхайчин, алтны худалдаачид хамарсан 241 хүнд (67 эр, 174 эм) зохион байгуулав.</p>
	<p>3-р зорилтын хүрээнд:</p> <p>Хүрэх үр дүн:</p> <p>1. Мэдлэгийн төвөөр дамжуулан 12 доошгүй хамтрагч байгууллагууд бичил уурхайн талаарх үйл ажиллагаанд оролцоход дэмжин ажиллана.</p> <p>2. Багадаа 18 удаа бичил уурхайн чиглэлээр хэрэгждэг төсөл тайлан/судалгааны материал МТ болон түнш байгууллагуудын цахим хуудсанд нийтэлсэн байна.</p> <p>3. Монгол Улсын Засгийн газар бусад орны бичил уурхайн сайн туршлагуудыг нэвтрүүлнэ. (Үүнд мөнгөн усгүйгээр хүдэр боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг албажуулах)</p> <p>4. Монгол Улсад болон бусад орнуудад бичил уурхайн талаар</p>	<p>3-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан</p> <p><b>Бүтээгдэхүүн 3.1. Бичил уурхайн мэдлэгийн менежмент болон түгээлт: Мэдлэгийн төвийн үйл ажиллагаа эхэлсэн байна.</b></p> <p>3.1.1. Бичил уурхайн талаарх мэдлэг, мэдээллийг хуваалцах Монголын мэдлэгийн төвийн цахим платформ болон мобайл аппликэйшнийг хөгжүүлэх. Мэдлэгийн төвийг бичил уурхайн олон улсын байгууллагууд, төсөл, хөтөлбөр болон сэдэвчилсэн бүлгүүдтэй харилцах боломжийг бүрдүүлэх. Олон улсын оролцогч талуудтай тогтмол цахим хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах.</p> <p>73. Бичил уурхайн мэдлэгийн төвийн цахим платформ хийх ажлыг Датаком компанитай 2016 оноос эхлэн хоёр жилийн хугацаатай гэрээлэн гүйцэтгүүлж байна. Гүйцэтгэлийн явц 70% байна. Мэдлэгийн төвийг албан ёсоор УУХҮЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хүлээлгэн өгнө. Мэдлэгийн төвийн албан ёсны нээлт 2018 оны 1 дүгээр улиралд болно.</p> <p>3.1.2. Мэдлэгийн төвийн бүтцийг бий болгох, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх. (Удирдах зөвлөл, Ажлын алба, сэдэвчилсэн бүлэг); Ажлын алба үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, оролцогч талуудыг зохицуулах, тогтмол уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, бичил уурхайн мэдээ, мэдээлэл бэлтгэх, түгээхэд дэмжлэг үзүүлэх; Мэдлэгийн төвийг чадавхжуулах, хэвийн үйл ажиллагааг хангах, олон улсын байгууллагуудтай холбоо харилцаа тогтооход мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.</p> <p>74. 2017 оны 3 дугаар сарын 25-нд Мэдлэгийн төвийн Удирдах зөвлөл нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж анхны хурлаа зохион байгуулсан. Хурлаар Мэдлэгийн төвийг цаашид МБУНДХ болон УУХҮЯ-ны аль нэг нь хариуцаж авч явах боломжтой гэж үзээд тус хоёр байгууллагаас төслийн санал авахаар шийдвэрлэсэн. Хоёр байгууллагын ирүүлсэн саналыг судалж үзээд Швейцарийн хөгжлийн агентлагаас Мэдлэгийн төвийн Ажлын албыг УУХҮЯ-нд хариуцуулахыг дэмжсэн. Одоогийн байдлаар Мэдлэгийн төвийн төслийн бичиг баримтыг яамтай хамтран англи монгол дээр боловсруулж УУХҮЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүлээлгэн өгсөн.</p> <p><b>Бүтээгдэхүүн 3.2. Сайн туршлага хуваалцах: Монголын оролцогч талууд үндэсний болон олон улсын хэмжээнд бичил уурхайн салбарын</b></p>

<p>хэрэгжүүлж байгаа нэгээс доошгүй төсөлд ХЭСХ-ыг тухайн төслийн төлөвлөлт болон үйл ажиллагаанд тусгаж үүнд ТБУТ хувь нэмэр оруулсан байна.</p>	<p><b>байгууллагуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгож, өөрсдийн мэдлэг, чадвар, туршлагаа хуваалцдаг байна.</b></p> <p><b>3.2.1. Бичил уурхайн үндэсний ба бүсийн чуулгануудыг зохион байгуулахад хамтрагч байгууллагуудад дэмжлэг үзүүлэх.</b></p> <p>75. Уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 95 жилийн ойн арга хэмжээний хүрээнд, 2017 оны 9-р сарын 5-07 өдрүүдэд Сүхбаатар аймагт Зүүн бүсийн чуулган уулзалт зохион байгуулахад Уул уурхай хүнд үйлдвэрийн яаманд дэмжлэг үзүүлсэн.</p> <p>76. Шинэчлэн батлагдсан бичил уурхайн журмын талаар мэдээлэл, ойлголт өгөх зорилгоор бүсийн сургалтыг нийт дөрвөн бүсэд (Сэлэнгэ, Өмнөговь, Увс, Баянхонгор аймгуудад) зохион байгуулсан бөгөөд сургалтаар бичил уурхай бүхий 15 аймаг, 70 сумын удирдлага, төрийн албан хаагчид, бичил уурхайчдын төлөөлөл болох 540 гаруй хүн шинээр батлагдсан бичил уурхайн хууль тогтоомжийн талаар нэгдсэн ойлголттой болж, гарын авлагаар хангагдсан. Сургалтад оролцогчдод Засгийн газраас шинэчлэн баталсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Бичил уурхайн аюулгүй байдлын дүрэм", Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал" болон Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг танилцуулж шинэ мэдээллийг өгсөн.</p> <p>77. УУХҮЯ, АМГТГ, ШХА-ийн Тогтвортой бичил уурхай төсөл хамтран "Хариуцлагатай бичил уурхайн төлөө хамтдаа" Үндэсний чуулганыг 2017 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан. Чуулганд УУХҮЯ, БОАЖЯ, ХНХЯ, Монголбанк, АМГТГ, МХЕГ, ЦЕГ, ҮСХ, Говь-Алтай, Увс, Ховд зэрэг бичил уурхай бүхий 18 аймаг, 78 сумын удирдлага, МСҮТ, хувийн хэвшил, МБҮНДХ болон бичил уурхайчдын төлөөлөл нийт 270 гаруй төлөөлөгч оролцсон. Чуулганаар бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон журам, дүрэм, аргачлалыг хэрэгжүүлэх талаар аймаг, сумдын орон нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын удирдлагууд, бичил уурхайчдын төлөөлөлд нэгдсэн ойлголт өгч буй юм. Мөн журмын хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх, хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоох, өөр ажлын байранд бичил уурхайчдыг шилжүүлэх боломж, алтны худалдааг албажуулах зэрэг асуудлын талаар хэлэлцсэн.</p> <p><b>3.2.2. Төслийн ажилтнууд болон хамтрагч байгууллагуудын төлөөллийг бичил уурхайн бодлогын асуудал, алтны борлуулалтын сүлжээ, мөнгөн усны хэрэглээг бууруулах, ХАБ-ын чиглэлээр чадавхжуулах, мэдлэг хуваалцах олон улсын хурал, чуулганд оролцоход дэмжлэг үзүүлэх.</b></p> <p>78. 2017 оны 5-р дугаар сарын 01-04-ний өдрүүдэд Франц Улсын Парис хотноо Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллагаас зохион байгуулсан Хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээний олон улсын чуулга уулзалтад Монголбанк болон Тогтвортой бичил уурхай төслийн төлөөлөл оролцлоо. Чуулганд Монгол Улсын бичил уурхайн нөхцөл байдал, ололт амжилтууд, бичил уурхайн Мэдлэгийн төвийн талаар Тогтвортой бичил уурхай төслөөс илтгэл тавьж оролцсон.</p> <p>79. Швейцарийн Женев хотноо "Бичил уурхайг зохицуулах нь" сэдвийн дор зохион байгуулагдсан Засгийн газар хоорондын чуулганы ээлжит 13 дугаар хуралдаанд УУХҮЯ болон Тогтвортой бичил уурхай төслийн төлөөлөл дөрвөн хүн оролцсон. Монгол Улсын бичил уурхайн эрх зүйн орчин, албажуулалтын талаар илтгэл танилцуулга бэлтгэхэд УУХҮЯ-нд дэмжлэг үзүүлсэн. Монгол Улсын УУХҮЯ-ыг Засгийн газар хоорондын чуулганы Удирдах зөвлөлд гишүүнээр сонгогдоход дэмжлэг үзүүлж, нөлөөллийн ажил хийсэн.</p> <p><b>3.2.3. Мэдлэгийн төвөөр дамжуулан олон улсын болон Монголын бичил уурхайн сайн туршлагуудын талаарх мэдээллийг түгээн дэлгэрүүлнэ. Бичил уурхайн талаарх ном, гарын авлага, тараах материал хэвлэн нийтлэх.</b></p> <p>80. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам бичил уурхайн хууль журам батлагдсантай холбогдуулан төслийн хүрээнд нийт 17 төрлийн 72,575,000 төгрөгийн үнэ бүхий гарын авлага, ном товхимлыг боловсруулж, хэвлэн олон нийтэд түгээсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бичил уурхайн хууль эрх зүйн орчин - 13,500 ширхэг</li> </ul>
---	--

- Бичил уурхайг албажуулах, зохион байгуулалтад оруулах - 13,500 ширхэг
- Бичил уурхайн сайн туршлагууд - 2,000 ширхэг
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн сайн туршлага - 1,500 ширхэг
- Бичил уурхайн алтны нийлүүлэлтийн сүлжээ - 5,000 ширхэг
- Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал - 1,000 ширхэг
- Шинэчилсэн журмын иргэдэд өгөх зөвлөмж плакат - 10,500 ширхэг
- Хоршоо болон нөхөрлөлийн тухай хууль - 4,000 ширхэг
- ААН-ийн болон ХАОАТ-ын тухай хууль - 4,000 ширхэг
- Алтны нийлүүлэлтийн сүлжээний сургалтын гарын авлага - 1,600 ширхэг
- Бичил уурхайчдад зориулсан татварын талаарх нугалбар - 4,000 ширхэг
- Шударга олборлолтын стандарт - 300 ширхэг
- ТБУТ-ийн товчоон - 1,000 ширхэг
- Ашигт малтмалын тухай хууль - 3,000 ширхэг
- Монголдоо хариуцлагатайгаар олборлов танилцуулга - 500 ширхэг
- Бичил уурхай дахь зөрчил, маргаан, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх арга зам - 3,000 ширхэг
- Бичил уурхайчдын оролцоо ба нөлөөллийн ажил харьцуулсан судалгааны тайлан - 300 ширхэг

**Бүтээгдэхүүн 3.3. Ижил төстэй туршлагаас суралцах: Бичил уурхайчид, бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон иргэний нийгмийн байгууллагууд харилцан суралцах, туршлага солилцох бололцоог бүрдүүлсэн байна.**

*3.3.1. Бичил уурхайн бодлого/зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх бусад улсын сайн туршлагыг судалж улмаар бичил уурхайн хууль тогтоомжийг сайжруулах, бичил уурхайг хөгжүүлсэн орнуудтай харилцаа холбоо тогтооход холбогдох талуудад дэмжлэг үзүүлэх*

81. 2.1.1-ийг үзнэ үү.

82. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж орон нутгийн төрийн байгууллага, бичил уурхай эрхлэгчид хамтран ажиллаж буй Баянхонгор аймгийн төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, алтны үндсэн орд дээр тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гурвалсан гэрээгээр ажиллаж буй "ХАМОДХ" ТББ болон "Хонгорын хүдэр" ХХК-ийн хүдэр баяжуулах цехийн үйл ажиллагаатай 5 аймгийн төрийн албан хаагчид, бичил уурхайчид, ХАМО иргэдийн төлөөлөл нийт 78 хүн бичил уурхайн байгууллагын сайн туршлагаас судлан танилцсан. Үүнд: Баян-Өлгий аймгаас 18 төрийн албан хаагч (15 эр, 3 эм), Говь-Алтай аймгаас нийт 20 хүн - төрийн албан хаагч 15 (12 эр, 3 эм), бичил уурхайчин 5 (4 эр, 1 эм), Өмнөговь аймгаас 12 хүн - төрийн албан хаагч 6 (4 эр, 2 эм), бичил уурхайчин 4 (2 эр, 2 эм), ХАМО иргэн (2 эр) Булган аймгаас 5 хүн - төрийн албан хаагч 3 (2 эр, 1 эм), бичил уурхайчин 2 (2 эр), Ховд аймгаас 23 хүн - төрийн албан хаагч 14 (14 эр, 1 эм), бичил уурхайчин 8 (7 эр, 1 эм) иргэд оролцсон.

*3.3.2. Мэдлэг хуваалцах ба дэмжлэг үзүүлэх замаар бичил уурхайн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон улсын төсөл/байгууллагуудтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх. (ДДБОС-ийн алтны төсөл, Минамата конвенцийн ҮҮАТ, АЭБХТ г.м.)*

83. Нидерланд Улсын алтаар үнэт эдлэл хийдэг дархан Нина Нанини Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ХАМОДХ ТББ-ын бичил уурхайчид болон хүдэр баяжуулах цехийн үйл ажиллагаатай танилцсан.

84. БОАЖЯ, Даян дэлхийн байгаль орчны сан, НҮБ-ын Байгаль орчны сангаас зохион байгуулсан "Алтны бичил уурхайгаас үүдэлтэй бохирдлыг бууруулах үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах" төсөл, "Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцийг хэрэгжүүлэх суурь үнэлгээ" төсөл, "Даян дэлхийн урт хугацааны хөгжлийн боломжууд" төслийн нээлтийн анхдугаар уулзалт 6 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж ШХА, ТБУТ-ийн удирдлагууд оролцож, ТБУТ-өөс "Бичил уурхай дахь мөнгөн усны хэрэглээ"-ний талаар мэдээлэл хийсэн.

85. БОАЖЯ-нд бичил уурхайн баяжуулах цех бүхий газруудад мөнгөн усны мониторингийн цооног суурилуулах ажилд дэмжлэг үзүүлсэн. Сэлэнгэ аймгийн Мандал сумын дэргэдэх баяжуулах цехүүд, Төв аймгийн Борнуур сумын ХАМО компанийн баяжуулах цехийн дэргэд болон Хараа голын ус судлалын харуулд нийт 3 цооног өрөмдөж газрын доорх усны мониторинг явуулах боломжтойгоор тоноглогсон.

		<p>86. БОАЖЯ-тай хамтран Байгаль орчин, геологи, уул уурхайтай холбоотой хууль тогтоомжийн эмхэтгэлийг 500 ширхэг хэвлэн нийт 21 аймгийн байгаль орчны байцаагч болон байгаль хамгаалагчдад тараасан.</p> <p><b>Бүтээгдэхүүн 3.4. Тогтвортой байдлыг хангах: Өнгөрсөн амжилтууд болон ирээдүйн сорилтуудыг холбосон санал хүсэлтийн зэрэг механизмыг бий болгосон байх</b></p> <p><i>3.4.1. Олон нийтэд бичил уурхайн талаар зөв ойлголтыг түгээн дэлгэрүүлэхэд УУХҮЯ, АМГТГ, ХЭҮК-той хамтран сэтгүүлчдэд бичил уурхай, хүний эрх, жөндөрийн ойлголтыг бий болгох</i></p> <p>87. ХЭҮК-ийн дэргэдэх “Хүний эрхийн төлөө - сэтгүүлчид” клубийн сэтгүүлчдэд бичил уурхайн асуудлыг хүний эрхийн өнцгөөс хэрхэн ойлгох, олон нийтэд хэрхэн зөв ойлголт өгөх талаар чадавх бэхжүүлэх зорилгоор зургаан удаа сургалт зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан сэтгүүлчид уул уурхай ба хүний эрх, байгаль орчны засаглал, бичил уурхай, аюулгүй байдал зэрэг сэдвээр нийт 34 мэдээ, сурвалжлага, нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэсэн.</p> <p>88. УУХҮЯ, АМГТГ-ын дэргэдэх “Уул уурхайн сэтгүүлч” клубийн эдийн засаг, уул уурхайн чиглэлээр дагнан бичдэг 20 (5 эр, 15 эм) сэтгүүлчтэй 2017 оноос эхлэн хамтран ажиллаж байна. Клубийн сэтгүүлчдэд бичил уурхайн талаар гурван удаагийн сургалт зохион байгуулж бичил уурхайн хууль эрхзүйн орчин, бичил уурхай дахь алтны нийлүүлэлтийн сүлжээ, аюулгүй байдал, бичил уурхайн сайн туршлагауд зэрэг сэдвүүдээр танилцуулга хийсэн. Сургалтад хамрагдсан сэтгүүлчид нийт 55 удаа телевизийн мэдээ, нийтлэлийг бэлтгэн олон нийтэд хүргэсэн. Мөн УУХҮЯ-тай хамтран “Хариуцлагатай бичил уурхай” сэдэвт шилдэг нийтлэл, нэвтрүүлгийн уралдааныг сэтгүүлчдийн дунд зарласан. Уралдаанд нийт 20 гаруй бүтээлийг сэтгүүлчид ирүүлсэн. Цаашид УУХҮЯ-тай хамтран сонгон шалгаруулалтыг хийж шилдэг бүтээлийг шалгаруулна.</p> <p>89. Дээрх клубуудын сэтгүүлчидтэй хамтран Баянхонгор аймгийн Баян-Овоо болон Галуут суманд очиж бичил уурхайн сайн туршлагыг судлан телевизийн 4 нэвтрүүлэг болон 12 нийтлэлүүдийг бэлтгэж сонин болон вэбсайтаар олон нийтэд түгээсэн. Нийт 23 (10 эр, 13 эм) сэтгүүлчдэд бичил уурхайн талаар мэдлэг ойлголт өгсөн.</p> <p><i>3.4.2. Хариуцлагатай бичил уурхай, нөхөн сэргээлт, ХАБ, нийгмийн даатгал, татвар, хүний эрх, жөндөр зэрэг чиглэлүүдээр бичил уурхайд хэрэгжүүлсэн сайн туршлага болон амжилтуудыг дэмжин, шагнаж урамшуулах ажлыг хамтрагч байгууллагуудтай хамтран зохион байгуулж, хэвлэл мэдээллээр түгээх.</i></p> <p>90. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмыг олон нийтэд таниулах кампанит ажлыг УУХҮЯ, АМГТГ-тай хамтран 2017 оны 6 сараас эхлэн хийж байна. Кампанит ажлын хүрээнд шинэчилсэн журмын талаар хэвлэл мэдээлэлд нийтлэл ярилцлага өгч журмын давуу тал болон зөвлөмжүүдийг олон нийтэд хүргэж байна. Кампанит ажлын хүрээнд нийт хоёр нэвтрүүлэг Баянхонгор аймгаас бэлтгэж үндэсний 5 болон орон нутгийн 3 сувгаар, мөн шторк хийж орон нутгийн болон үндэсний 12 телевизийн сувгаар цацалт хийсэн. Шинэчилсэн журмын талаар нийт өдөр тутмын 4 сонин, 4 вэбсайт, 5 үндэсний телевизэд УУХҮЯ болон ТБУТ-ийн төлөөлөл ярилцлага болон нийтлэлийг гарган олон нийтэд хүргэсэн.</p> <p>91. Алтны нийлүүлэлтийн сүлжээний албажуулалтын талаар олон нийтэд ойлголт өгөх зорилгоор өдөр тутмын сонин болон вэбсайтад энэ талаар нийтлэл, мэдээлэл, ярилцлага өгсөн.</p> <p>92. Төслийн вэб хуудас болон хоёр сар тутмын электрон мэдээллийн хуудсаар дамжуулан нийт 300 гаруй хэрэглэгчдэд англи монгол хэл дээр Монгол Улсын бичил уурхайн салбарт болж буй үйл явдал болон Тогтвортой бичил уурхай төслийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг түгээж байна.</p>
7.	Дүгнэлт дутагдал, асуудлууд) (ололт, анхаарах	<p>Дүгнэлт: 2017 онд Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулагдсан болон төрийн байгууллагуудын боловсон хүчний сэлгээтэй холбогдон зарим үйл ажиллагааны хэрэгжилт хойшилсон боловч төслийн хамтрагч байгууллагууд хамтарч сайн ажилласны үр дүнд бичил уурхайн эрх зүйн орчин сайжирсан, төслийн үйл ажиллагааны хэрэгжилт хэрэгжилт сайн байсан.</p> <p>Ололт: Төслийн хэрэгжилтийн хүрээнд бичил уурхайчдын ТББ-ууд, иргэний нийгмийн 6 ТББ, бичил уурхай бүхий 13 аймгийн ЗДТГ-тай гэрээ байгуулж дэмжлэг үзүүлж</p>

			<p>ажилласнаар бичил уурхайчид зохион байгуулалтад орох үйл явцад ахиц дэвшил гарч, улмаар байгаль орчны хариуцлага сайжирч 39 га газарт нөхөн сэргээлт хийсэн байна.</p> <p>Дутагдал: Бичил уурхайн асуудлаар төрийн төв болон орон нутгийн бүх байгууллагууд үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, асуудал хариуцсан мэргэжилтэн томилж ажиллуулдаг болсон боловч эдгээр байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалттай биш байгаа нь төсөв хөрөнгө тарамдах, зарим үйл ажиллагаа нь давхцах зэрэг асуудал гарч байлаа.</p> <p>Анхаарах асуудлууд: Бичил уурхайн талаарх төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор баталсан журамд заасны дагуу салбар хоорондын зөвлөл байгуулах, Төсөл 2019 онд хаагдах тул Монгол Улсын Засгийн газар бичил уурхайн талаарх төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх боломжийг судлах,</p>			
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийн хамтрагч талууд үр дүнтэй хамтарч ажилласан.				
		Төслийн хэрэгжилтийн хүрээнд 2017 оны 3-12 сарын хооронд:				
		- Шийдвэр гаргах түвшинд УУХҮЯ-аас гадна БОАЖЯ, ЭМЯ, ХНХЯ, ХЭҮК-той				
		-Засгийн газрын агентлагийн түвшинд АМГТГ, ОБЕГ/УУАА, ХХҮЕГ, НДЕГ-тай				
		-Орон нутгийн түвшинд: бичил уурхайчид болон ХАМО иргэдэд хүрч ажиллах аймаг, сумдын төрийн байгууллагын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх зорилгоор Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Хэнтий, Дундговь, Өмнөговь, Булган, Өвөрхангай зэрэг 13 аймгийн Засаг дарга нартай				
		- Төрийн бус байгууллагын түвшинд: Бичил уурхайн хууль тогтоомжийг сурталчлах, бичил уурхайн зохион байгуулалт, албажуулалтын чиглэлийн сургалтыг орон нутагт зохион байгуулах зорилгоор Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо болон 6 аймгийн (Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Ховд, Хэнтий, Увс) иргэний нийгмийн байгууллагуудтай тус тус хамтран ажиллах гэрээ байгуулж үр дүнтэй хамтран ажилласан.				
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		85%	15	98.1 %	69.34%	83.46%
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (УУХҮЯ)	Нэгдсэн үнэлгээ				
		100%				
11	(ЗГХЭГ-ын үнэлгээ)					

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл						
1.	Төслийн Нэр: “Монгол Улсад олборлох салбарын удирдлагыг бэхжүүлэх	СЕСМИМ төслийн зорилго нь төрийн байгууллагуудын менежментийг сайжруулах арга замаар олборлох салбарын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх						
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Буцалтгүй тусламж						
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Канад Улсын Засгийн газрын СЕСМИМ төсөл болон Ашигт малтмал, газрын тосны газар Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:						
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Төрийн байгууллагуудын менежментийг сайжруулах арга замаар олборлох салбарын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулахад мэргэжилтнүүдийг сургалтад хамруулж, мэргэшүүлэх						
5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	Буцалтгүй тусламж					
		Үүнд:	Төсөв (он)		Гүйцэтгэл		Хувь	
		Багц 1						
		Багц 2 (г.м)						
	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.						
6.	1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1:	Канад Улсын Гадаад хэргийн яамны санхүүжилттэй Монгол Улсын Олборлох салбарын менежментийг бэхжүүлэх (СЕСМИМ) төслийн 2017-2018 оны ажлын төлөвлөгөөний хүрээнд 2017 оны 4-р сарын 1-ээс мөн оны 9-р сарын 30-ыг хүртэл зохион байгуулсан уулзалт, семинар, сургалтад Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газрын төлөөлөгчид хамрагдсан. СЕСМИМ төслийн санхүүгийн тайлант хугацаа буюу 2017 оны 4-9-р сарын байдлаар зохион байгуулсан нийт 33 уулзалт, арга хэмжээний 61% буюу 20 арга хэмжээнд Ашигт малтмал, газрын тосны газрын мэргэжилтнүүдийн төлөөллийг хамруулж чадавхыг бэхжүүлэхэд чиглэн ажилласан.						
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	СЕСМИМ төсөл нь олборлох салбарын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд Ашигт малтмал, газрын тосны газар нь төслийн гол хамтрагч бөгөөд энэхүү төслийг 2018 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тохиролцсон. Канад улсад зохион байгуулсан сургалтуудад мэргэжлийн хэлтсүүдийн мэргэжилтнүүдийг оролцуулж байсан нь давуу тал байлаа.						
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Канад Улсын Засгийн газраас хэрэгжүүл буй СЕСМИМ төслийн баг мэргэжлийн өндөр ур чадвартай, үйл ажиллагаануудыг цаг тухайд нь зохион байгуулж ажилласан.						
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3		
		40%		40%	... %	... %		
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ УУХҮЯ	Нэгдсэн үнэлгээ 40%						
11.	(ЗГХЭГ-ын үнэлгээ)							



**Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд\* хэрэгжиж байгаа гадаад зээл, тусламжийн төслүүдийн үнэлгээ  
/2017 оны эцсийн байдлаар/**

№	Төслийн нэр	Санхүү- жүүлэгч	Эхлэх/ дуусах хугацаа	Санхүү- жилтийн дүн	Үүнээс:		2017 оны үнэлгэ э**	Хэрэгжилт (хувиар)***	Тайлбар /хүрсэн үр дүн, тулгамдаж буй асуудал/
					Буцалтгүй тусламж	Зээл			
1	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (MINIS)	Дэлхийн банк	2011.11.21-2019.09.30	29,050,000	4,050,000	25,000,000	70	78	Төслийн удирдах хороог яаралтай хуралдуулж худалдан авалтын төлөвлөгөө батлах, шинэ төслүүдийн саналыг шийдвэрлэх
2	Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) 4-р үе шат	Швейцарын Холбооны Улсын Засгийн газар	2015-2018	6 000 000 Швейцар франк	6 000 000 Швейцар франк		100	85	
3	Монгол Улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх (СЕСМИМ) төсөл	Канад улсын Засгийн газар	2016-2022	.....	.....	-	40	40	СЕСМИМ төсөл нь олборлох салбарын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд Ашигт малтмал, газрын тосны газар нь төслийн гол хамтрагч бөгөөд энэхүү төслийг 2018 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тохиролцсон. Канад улсад зохион байгуулсан сургалтуудад мэргэжлийн хэлтсүүдийн мэргэжилтнүүдийг оролцуулж байсан нь давуу тал байлаа.
4	Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT). Хүний нөөцийн ур чадварт суурилсан тогтолцоо-MERIT	Канад улсын Засгийн газар	2017.01 сар	.....	.....	-	40	70	Төслийг хэрэгжүүлэхэд Ашигт малтмал, газрын тосны газрын холбогдох хэлтсүүдийн мэргэжилтнүүд Канад улсаас ирсэн зөвлөхтэй хамтран ажиллах шаардлага тулгарсан бөгөөд энэ нь тухайн мэргэжилтнүүдийн хувьд өөрсдийн үндсэн ажлын цагтай давхцан цаг хугацааны хувьд хүндрэл болж байсан. Олборлох салбар хөгжсөн Канад улсаас чиглэл бүрээр туршлагатай мэргэжилтнүүд ирж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн нь Ашигт малтмал, газрын тосны газрын бүх түвшний ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, гүйцэтгэлийн үнэлгээ зэргийг илүү тодорхой болгоход дөхөм болсон.

5	Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /АМЕР/. Веб-д суурилсан Геологийн мэдээллийн метадата-каталоги систем /Монгеокат/-ийг хөгжүүлэх, АМЕР	Австрали улсын Засгийн газар	2015.02 сараас 2019.04 сар хүртэл	5,000,000 австрали доллар	5,000,000 австрали доллар	-	70	70	АМЕР төслийн баг мэргэжил, арга зүйн хувьд чадварлаг байсан нь төслийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд төхөм болсон. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газрын холбогдох ажилтнуудтай хамтран ажилласан бөгөөд Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн мэргэжилтнүүд үндсэн ажлын хажуугаар геологийн мэдээллийн хураангуйг МонГеоКат” систем руу оруулах боломж хязгаарлагдмал байсан.
6	АМГТГ-ын Уул уурхай, газрын тосны төв лабораторийн үйл ажиллагааг дэмжих-К-Петро /БНСУ-ын Газрын тосны чанар болон түгээлтийн газар/	БНСУ-ын К-Петро байгууллага болон АМГТГ-ын өөрсдийн санхүүжилтэ эр	2017.04 сар /Жил бүр гэрээ хийж хугацааг сунгана./	-	-	-	40	90	Төсөл нь 2017 оны 4 сард санамж бичигт гарын үсэг зурснаар хэрэгжиж эхэлсэн байгаа бөгөөд төслийн хэрэгцээ шаардлага нь Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, газрын тосны тосны туршилтын лабораторын тоног төхөөрөмжүүдийг бүрэн ажиллагаанд оруулах, лабораторийн ажилчдыг шаардлагатай сургалтад хамруулах зэрэг Ашигт малтмал, газрын тосны газрын нэн тэргүүний шаардлагуудад нийцсэн. Одоогийн байдлаар БНСУ-ын болон Монгол Улсын Засгийн газруудаас санхүүжилт байхгүй К-Петро-ийн өөрсдийн дотоод санхүүжилтээр мэргэжилтнүүдийг БНСУ-д авчирч сургалтуудыг амжилттай зохион байгуулаад байна. Цаашдаа КОЙКА-аар дамжуулан БНСУ-ын Хөгжлийн байгууллагаас шаардлагатай санхүүжилтийг олгуулахаар төлөвлөж байна.

7	Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх төсөл-КИГАМ	БНСУ-ын Геологийн шинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн	2014-2017 гэрээ сунгаж байгаа	72000 ам доллар	72000 ам доллар	-	70	90	Төслийн 2017 оны хээрийн ажлыг Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:50000-ны масштабын геологийн зураглал ерөнхий эрлийн ажлыг хийх заавар тавих шаардлагын дагуу амжилттай хийсэн. Энэ нь өмнөх жилүүдийг бодвол кондицийн гэдэг утгаараа ололттой болсон. Төслийн хээрийн ажлыг хэрэгжүүлэхэд БНСУ-ын КИГАМ-тай гэрээ байгуулсан хугацаа болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан хээрийн ажил оройтож эхэлсэн нь гэрээт хугацаанд төлөвлөгөөт ажлыг гүйцэтгэхэд цаг хугацааны хувьд шахуу байсан. Дараа жилийн хээрийн ажил болон суурин боловсруулалтын ажлын хугацааг харгалзан тооцож эрт гэрээг байгуулах шаардлагатай. Мөн төсөл дээр ажиллаж буй мэргэжилтнүүд солонгос мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахын тулд хэлний болон мэргэжлийн сургалтанд суулгах шаардлагатай байна.
---	--	---	-------------------------------	-----------------	-----------------	---	----	----	--

Тайлбар:

\* Агентлагууд дээр хэрэгжиж буй төслүүдийг хамруулна.

\*\*Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлгээг хийнэ.

\*\*\* Төслийн хэрэгжилтийг хувиар тооцож гаргана.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хянасан: ХШҮДАГ-ын дарга

Нэгтгэсэн: ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн

ХШҮ хийсэн: ХШҮДАГ-ын мэргэжилтэн

Ц.Одхүү

Н.Баатар /2018.02.26/

Д.Батнайрамдал

## Төслийн санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт

№	Төслийн нэр	Нийт санхүүжилт /USD/			2017 оны			Үүнээс:					
					Санхүүгийн жил			Урсгал зардал			Хөрөнгө оруулалтын зардал		
		Гэрээний дүн	Зарц.* /өссөн дүн/	%	Төсөв	Гүйцэтгэл	%	Төсөв	Гүйц.	%	Төсөв	Гүйц.	%
1	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (MINIS)												
	1.1. Хар төмөрлөгийн үйлдвэрийн ТЭЗҮ	1,357,510	1,357,510	100									
	1.2. Хар төмөрлөгийн БОННУ	218,215	139,008	64									
	1.3. Нүүрснээс байгалийн хий боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ	1,597,832	1,597,832	100									
	1.4. Нүүрснээс байгалийн хий боловсруулах үйлдвэрийн БОННУ	402,149	195,120	49									
2	Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) 4-р үе шат /Швейцар франк/	6,000,000	4,558,565	76	1,591,600	1,353,380	85	25,500	25,500	100	1,566,100	1,327,454	85
3	"Монгол Улсад олборлох салбарын удирдлагыг бэхжүүлэх-СЕСМИМ												
4	Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT). Хүний нөөцийн ур чадварт суурилсан тогтолцоо-MERIT												
5	Австрали- Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /АМЕР/. Веб-д суурилсан Геологийн мэдээллийн метадата-каталоги систем /Монгеокат/-ийг хөгжүүлэх, АМЕП /австрали доллар/	5,000,000	3,760,000	75	1,000,000	1,000,000	100						
6	АМГТГ-ын Уул уурхай, газрын тосны төв лабораторийн үйл ажиллагааг дэмжих- К-Петро												
7	Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх төсөл-КИГАМ /ам доллар/				72,000	72,000	100						
	<b>НИЙТ ДҮН</b>	14,575,706	11,608,035		2,663,600	2,425,380		25,500	25,500		1,566,100	1,327,454	

Тайлбар:

\* Төсөл хэрэгжиж эхэснээс хойш хийгдсэн ашиглалт заагдсан төсөл хэрэгжих хугацаанаас хэдий хугацаа ашиглаад буйг тооцно.

\*\* Нийт гэрээнд заагдсан санхүүжилтийнхээ хэдэн хувийг ашигласан болохыг тооцно.

## УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хянасан: ХШУДАГ-ын дарга

Нэгтгэсэн: ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн

ХШУ хийсэн: ХШУДАГ-ын мэргэжилтэн

Ц.Одхүү

Н.Баатар /2018.02.26/

Д.Батнайрамдал

## Төслийн санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт

№	Төслийн нэр	Төслийн хэрэгжилтийн хугацаа /жилээр/		Ашиглалт /хувиар/		Үүнээс: 2017 оны санхүүгийн жилд		
		Гэрээнд заагдсан хугацаа	Хэрэгжүүлж байгаа хугацаа	Төсөл хэрэгжих хугацааны*	Нийт санхүүжилт**	ТХН-ийн үйл ажиллагааны зардал	Дотоод зөвлөх үйлчилгээ	Гадаад зөвлөх үйлчилгээ
1	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (MINIS)							
	1.1. Хар төмөрлөгийн үйлдвэрийн ТЭЗҮ	2 жил	2 жил	100	100			
	1.2. Хар төмөрлөгийн БОННУ	2 жил	3 жил	67	67			
	1.3. Нүүрснээс байгалийн хий боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ	2 жил	2 жил	100	100			
	1.4. Нүүрснээс байгалийн хий боловсруулах үйлдвэрийн БОННУ	2 жил	3 жил	67	67			
2	Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) 4-р үе шат /Швейцар франк/	4 жил	3 жил 1 сар	76	76	216,000		
3	"Монгол Улсад олборлох салбарын удирдлагыг бэхжүүлэх- СЕСМИМ							
4	Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT). Хүний нөөцийн ур чадварт суурилсан тогтолцоо-MERIT							
5	Австрали- Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /АМЕР/. Веб-д суурилсан Геологийн мэдээллийн метадата-каталоги систем /Монгеокат/-ийг хөгжүүлэх, АМЕП /австрали доллар/	4 жил 2 сар	3 жил	75	75	100,000	500,000	400,000
6	АМГТГ-ын Уул уурхай, газрын тосны төв лабораторийн үйл ажиллагааг дэмжих, К-Петро							
7	Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх төсөл-КИГАМ							
<b>НИЙТ ДҮН</b>						316,000.00	500,000.00	400,000.00

Тайлбар:

\* Төслийн гэрээ, хэлэлцээрт заагдсан төсөл хэрэгжих хугацаанаас хэдий хугацаа ашиглаад буйг тооцно.

\*\* Нийт гэрээнд заагдсан санхүүжилтийнхээ хэдэн хувийг ашигласан болохыг тооцно.

Хянасан: ХШУДАГ-ын дарга

Нэгтгэсэн: ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн

ХШУ хийсэн: ХШУДАГ-ын мэргэжилтэн

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Ц.Одхүү

Н.Баатар /2018.02.26/

Д.Батнайрамдал

## Төслийн төлөвлөсөн ажлын биелэлт

№	Төслийн нэр	Бүрэлдэхүүн хэсгийн тоо	Бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийх ажлын тоо	Үүнээс: Биелэлт хангалтгүй	Бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтийн хувь	Тайлбар
1	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	4	20	6	70	Хэрэгжээгүй ажлуудын шалтгаан нь төслийн хэрэгжилтийн стратегийг тодорхойлоход онцгой ач холбогдол бүхий Сэлэнгэ мөрний сав газарт байрлах "Шүрэнгийн усан цахилгаан станц" төсөл болон Орхон гол дээр урсацын тохируулга хийх "Орхон говь" төслүүдийн ТЭЗҮ болон БОННУ-г боловсруулах зөвлөх компаниудыг сонгон шалгаруулахаар төлөвлөж байсан хэдий ч эдгээр ажлуудын ажлын даалгаврыг Дэлхийн банкны хамгааллын бодлогын дагуу Оросын холбооны улсын Буриад улсад олон нийтийн хэлэлцүүлгүүд зохион байгуулж дээрхи хоёр төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй оролцогч талуудын дунд хэлэлцүүлэх шаардлага тулгарсан. Энэхүү хэлэлцүүлгийн үр дүнд "Шүрэнгийн усан цахилгаан станц" төсөл болон Орхон гол дээр урсацын тохируулга хийх "Орхон говь" төслүүдийн ТЭЗҮ болон БОННУ-г төслийн хүрээнд хийхээр төлөвлөснийг цуцалсан ба хоёр төслийн Бүс Нутгийн Байгаль Орчны Үнэлгээ /БНБОУ/-г нэгтгэн Сэлэнгэ мөрний сав газар, Байгал нуур болон Ангар мөрөн дээрх 4 усан цахилгаан станцыг хамруулан судалгааны ажлыг хийж гүйцэтгэхээр шийдвэрлэсэн. Одоогоор Бүс нутгийн байгаль орчны үнэлгээний ажлын ажлын даалгаврыг бэлтгэж байна.
2	Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) 4-р үе шат Бүрэлдэхүүн 1	1	14		100	
	Бүрэлдэхүүн 2	1	16	3	81.25	Холбогдох байгууллагуудаас тодорхой шийдвэр гараагүй тул орон нутагт алт худалдан авах нэг цэгийн үйлчилгээний төв байгуулах ажил хийгдээгүй.
	Бүрэлдэхүүн 3	1	10	2,7	73	

3	"Монгол Улсад олборлох салбарын удирдлагыг бэхжүүлэх-СЕСМИМ, /АМГТГ, УУХҮЯ, БОАЖЯ, СЯ/	-	-			
4	Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT). Хүний нөөцийн ур чадварт суурилсан тогтолцоо-MERIT, /АМГТГ 2 мэргэжилтэн, MERIT төслийн баг/	1	5			
5	Австрали- Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /АМЕР/. Веб-д суурилсан Геологийн мэдээллийн метадата-каталоги систем /Монгеокат/-ийг хөгжүүлэх, АМЕР, /АМГТГ-ын 3 мэргэжилтэн/	1	17			
6	АМГТГ-ын Уул уурхай, газрын тосны төв лабораторийн үйл ажиллагааг дэмжих- К-Петро, /Лабораторийн 10 мэргэжилтэн, БНСУ-ын К-Петро байгууллагын төслийн баг/	1	3			
7	Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх төсөл-КИГАМ /АМГТГ-ын 2 мэргэжилтэн, Гэрээт ажилтан 11, БНСУ-ын төслийн баг/	1	4			
<b>НИЙТ ДҮН</b>		11	89	9	324.25	

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хянасан: ХШУДАГ-ын дарга

Нэгтгэсэн: ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн

ХШУ хийсэн: ХШУДАГ-ын мэргэжилтэн

Ц.Одхүү

Н.Баатар /2018.02.26/

Д.Батнайрамдал

## Төслийн хүрээнд бий болсон ажлын байр, сургалтын судалгаа

## А.Ажлын байрны судалгаа

№	Төслийн нэр	Төслийн ажилтны тоо*	Төслийн хүрээнд шинээр бий болсон ажлын байрны тоо**		Шинээр бий болох
			Нийт /өссөн дүнгээр/	2017 оны байдлаар	2018 онд
1	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	10	44	10	
2	Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) 4-р үе шат	10	0	0	
3	Монгол Улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх (СЕСМИМ) төсөл				
4	Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT). Хүний нөөцийн ур чадварт суурилсан тогтолцоо-MERIT				
5	Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр - веб-д суурилсан Геологийн мэдээллийн метадата-каталоги систем /Монгеокат/-ийг хөгжүүлэх, АМЕП	5	20 богино хугацааны зөвлөхүүд,	5	Ойролцоогоор 3 компанитай гэрээ байгуулан ажиллана. 3-4 богино хугацааны зөвлөхүүд гэрээлэн ажиллана.
			урт хугацааны ажилтан-2,		
			5 Монгол компанитай гэрээ байгуулан ажилласан		
6	АМГТГ-ын Уул уурхай, газрын тосны төв лабораторийн үйл ажиллагааг дэмжих-К-Петро	2	2	2	Тодорхой болоогүй
7	Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх төсөл-КИГАМ	10	13	10	12

\* Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын болон урт хугацааны дотоод зөвлөхүүдийг, нэгжгүй тохиолдолд урт хугацааны дотоод зөвлөхүүдийг хамруулна.

\*\* Төслийн үр дүнд бий болсон ажлын байрыг хамруулна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хянасан: ХШУДАГ-ын дарга

Ц.Одхүү

Нэгтгэсэн: ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн

Н.Баатар /2018.02.26/



Б.Сургалтын судалгаа

№	Төслийн нэр	Сургалтын тоо		Сургалтад хамрагдсан хүний тоо		Сургалтад хамрагдсан байгууллагын нэрс
		Нийт	Үүнээс: 2017 онд	Нийт	Үүнээс: 2017 онд	
1	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл	161	12	5633	2264	ЗТБХБЯ, ТЗГазар, СЯ, ЭЗХЯ, ЭХЯ, ҮХААЯ, БОАЖЯ, ТӨХ, УУЯ, ХЗЯ, АҮЯ, БХБЯ, Сав
2	Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) 4-р үе шат	89	43	37391	20788	ОБЕГ/ УУАА, НДЕГ, НДЕГ, ХНХЯ-ны орон нутгийн Нийгмийн даатгалын хэлтэс, ХХҮ-ний хэлтсүүд, МХЕГ, ХХҮЕГ, ЭМЯ-ны орон нутгийн ЭМГ-ын эмч нар, 18 аймгийн ЗДТГ, орон нутгийн МХ-ын геологи, уул уурхай байгаль орчны байцаагч нар, БОАЖГын байгаль хамгаалагч нар, 78 сумын ЗД нар, ЗДТГ-ын мэргэжилтгүүд, Бичил уурхайчдын 78 ТББ-ын гишүүд
3	Монгол Улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх (СЕСМИМ) төсөл					
4	Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT). Хүний нөөцийн ур чадварт суурилсан тогтолцоо-MERIT					
5	Австрали- Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /АМЕР/. Веб-д суурилсан Геологийн мэдээллийн метадата-каталоги систем /Монгеокат/-ийг хөгжүүлэх, АМЕП	15	8	100	27	АМГТГ-ын Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв, УУХҮЯ
6	АМГТГ-ын Уул уурхай, газрын тосны төв лабораторийн үйл ажиллагааг дэмжих- К-Петро					
7	Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх төсөл-КИГАМ					

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хянасан: ХШҮДАГ-ын дарга

Нэгтгэсэн: ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн

ХШҮ хийсэн: ХШҮДАГ-ын мэргэжилтэн

Ц.Одхүү

Н.Баатар /2018.02.26/

Д.Батнайрамдал



2018 он 02 сар 23 өдөр

ДУГААР 2018/008

УЛААНБААТАР ХОТ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН  
ДАРГА Ж.АНУН ТАНАА

Хариу өгөх тухай

“Институцийн өөрчлөлт хийх замаар төрийн эрдэс баялгийн менежментийг сайжруулах санаачлага” (MERIT) төсөл нь олборлох салбарыг үр дүнтэй удирдахад төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр Канадын Гадаад хэргийн яамны санхүүжилттэй 7 жилийн хугацаанд хэрэгжиж байна.

Монгол улсад Канад улсын хөгжлийн түслэмжийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичгийг хоёр улсын Засгийн газар хооронд 2016 оны 9 сарын 08-ны өдөр байгуулсан билээ. Тус Санамж бичгийн 7 дугаар зүйл: Тайлагнах зохицуулалт -д “Канад улсын Засгийн газар Монгол улс дахь элчин сайдын яамаараа дамжуулан жилийн тайлан, хараат бус хяналтын тайланг Монгол улсын засгийн газарт Сангийн яамаар дамжуулан хүргүүлэх бөгөөд гадаадын түслэмжийг хүлээн авах, зарцуулах, удирдах, бүртгэх тайлагнах тухай Монгол улсын дүрэм журамтай нийцүүлнэ” хэмээн заасан ёсоор Та бүхэн Сангийн яамаар дамжуулан Канадын элчин сайдын яаманд хандаж шаардлагатай мэдээллийг авна уу.

Хамтран ажиллаж буй Та бүхэнд талархал илэрхийлье.

